

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-33
<hr/>	
1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	7-10
2.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 5 гишүүн 2023.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	10-19
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	19-20
4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	20-21
5.Аймаг дундын отрын бүс нутгийн нөхцөл байдлыг судалж, Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох	21-33
6.Байнгын хорооны тогтоолын төсөл /Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай/	33

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны
07 дугаар сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 38 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Г.Ганболд, Б.Саранчимэг, Ц.Туваан;

Чөлөөтэй: О.Цогтгэрэл;

Тасалсан: Г.Тэмүүлэн.

Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд М.Ганбаатар, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Эрдэнэбадрах, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ш.Цэрэндулам, Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга Б.Буяннэмэх, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Г.Эрдэнэбилэг, мөн хэлтсийн ахлах нягтлан бодогч Л.Оюунчимэг, Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн П.Баярцэцэг, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Ойн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунсанаа, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Болдбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Ерөнхий нягтлан бодогч П.Энхбаяр, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нар танилцуулав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлт болон Засгийн газрын танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 5 гишүүн 2023.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Ж.Батжаргал, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд,

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийн талаар хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Б.Бейсен, Ц.Идэрбат, Ц.Туваан нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Байнгын хорооны тогтоолын төсөл /Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийн талаар хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ж.Бат-Эрдэнэ: “Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Ганбаатар, Н.Ганибал, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир, Б.Жаргалмаа нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Аймаг дундын отрын бүс нутгийн нөхцөл байдлыг судалж, Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ц.Рэнцэнтөгтох нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их хурлын гишүүн Б.Бейсений тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: “Аймаг дундын отрын бүс нутаг, бэлчээр ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 7
Бүгд: 11
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл /Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ж.Бат-Эрдэнэ: “Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 49 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 38 минут.

**БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Бат-Эрдэнэ: Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 52,6 хувьтай болсон тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааныг эхлүүлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Тлеуханы Аубакир гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Наянтайн Ганибал гишүүн ирсэн. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн ирсэн. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн ирсэн. Төмөртоогоогийн Энхтүвшин нарын гишүүд ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 6 асуудал байна.

1. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

3. Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсэг байгуулах тухай.

4. Байнгын хорооны тогтоолын төсөл. Газрын тухай хууль болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

5. Аймаг дундын отрын бүс нутгийн нөхцөл байдлыг судалж, Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийг сонсох.

6. Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм. 6 дугаар асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж батлах тухай гэсэн ийм 5 асуудал байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэж байгаа асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал.

1. Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийг өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхлэе.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Жавхлан Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, Д.Занданбат Монгол улсын ерөнхий аудитор, Ц.Наранчимэг Монгол улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Я.Самбууням Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын дарга, Тэргүүн аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор. Сангийн яамныхан орж ирж байна. Сангийн яамныхныг уриарай.

Байгаль орчны яамны ажлын хэсэгт М.Ганбаатар дэд сайд, С.Цогтгэрэл БОАЖЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ш.Цэрэндулам мөн яамны Уур амьсгалын өөрчлөлт бодлого төлөвлөлтийн газрын дарга, Ц.Уранчимэг мөн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Я.Болдбаатар мөн яамны Усны газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Г.Эрдэнэбилиг мөн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Л.Оюунчимэг мөн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах нягтлан бодогч, С.Энхтүвшин Цаг уур шинжилгээний газрын дарга, ХХААХҮЯ Х.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд ирсэн байна. Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, П.Энхбаяр ХХААХҮЯ-ны ерөнхий нягтлан бодогч, Ж.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нар ирсэн байна.

Ингээд Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Ц.Наранчимэг. Ц.Наранчимэг хэддүгээр микрофон байна? 3 дугаар микрофон, 3 дугаар микрофоныг нээе, танилцуулгаа хийнэ үү.

Ц.Наранчимэг: Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын тухай хуульд заасан

бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчдын 22 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 92 тайлан нэгтгэгдсэнээс 77 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гарган, 15 байгууллагыг аудитын түүвэрт хамруулж, аудитаар хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 70 байгууллагын санхүүгийн тайланд өөрчлөлтгүй, 6 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай, 1 байгууллагын санхүүгийн тайланд сөрөг дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0,6 тэрбум төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 1,4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 53 албан шаардлага, хариуцлага тооцох 4 албан шаардлага, 0,3 тэрбум төгрөгийн 7 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 8,5 тэрбум төгрөгийн зөрчилд 80 зөвлөмжийг хүргүүлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17,7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 31 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнээс шилжин хэрэгжих 23,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11, шинээр хэрэгжих 25,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээ байна. Нийт төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэл 62,2 хувьтай бөгөөд хэрэгжиж дууссан 9, хэрэгжилт дутуу 22 төсөл арга хэмжээ байна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Санхүүжилтийн гүйцэтгэл 87 хувьтай байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 64 тайлан нэгтгэгдсэнээс 60 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулж, аудитаар хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд 48 байгууллагад өөрчлөлтгүй, 10 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өглөө. Аудитаар нийт 495,8 тэрбум төгрөгийн 168 зөрчил илэрснээс 0,2 тэрбум төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 492,9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 72 албан шаардлага, 2,7 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 75 зөвлөмжийг хүргүүлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 150,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 41,3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 77 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнээс шилжин хэрэгжих 44,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 22, шинээр хэрэгжих 106 төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл, арга хэмжээ байна. Нийт төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 55,8 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл нь 86 хувьтай байна.

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн цаашид анхаарах асуудлаар дараах асуудлыг толилуулж байна. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт хүрэх түвшин тодорхойгүйгээс улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар

хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа зөрчил арилахгүй байгаа гол шалтгаан болж байна.

Гадаад, дотоод зээлийн эх үүсвэр болон Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөс иргэн, хуулийн этгээдэд олгосон зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд байршуулаагүйгээс хэд хэдэн эх үүсвэрээс давхардуулан зээл авсан. Зээлийн баталгаа чанаргүй болж гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй, зээлийн эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэл нэмэгдэж байна. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, мөн төсөвт ачаалал үүсгэж буй талаар жил бүр хийгдэж байгаа аудитын дүн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй зөрчсөн хэвээр байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Наранчимэг аудиторт баярлалаа.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаар танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн Х.Болорчулуун. Сангийн сайд Болдын Жавхлан хуралтай байгаа тул Х.Болорчулуун гишүүн. Болорчулуун сайдын микрофоныг нээе. Болорчулуун гишүүний микрофоныг нь нээе.

А.Болорчулуун: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэж гаргах. Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 07 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17,1 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18,1 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтайгаар төлөвлөгдсөн дүнгээс 1,8 их наяд төгрөгөөр буурсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын нийт 152 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 343 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардал 285,5 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 51 тэрбумыг тус тус зарцуулсан.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 30 хувь буюу 103,9 тэрбум төгрөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багц, 69,7 хувь буюу 239,2 тэрбум төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын зарлагыг эзэлж байна. Улсын төсвөөс 329,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 52,9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, та бүхэн 2022 энэ төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын

дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 22 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон аудитын дүгнэлттэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Алга байна.

Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулъя. Батжаргал гишүүн танилцуулъя.

1 дэх асуудал хэлэлцэж дууслаа.

14.51 цаг

2 дахь асуудал.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганибал гишүүн танилцуулъя. Ганибал гишүүний микрофоныг өгье, нээе.

Н.Ганибал: Өдрийн мэнд хүргэе. Хөдөө аж ахуйн газар нь манай орны газар ашиглалтын уламжлалтай холбоотойгоор газрын нэгдмэл сангийн дийлэнх хэсгийг эзлэх боловч сүүлийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

жилүүдэд гарч буй газар ашиглалтын хэлбэр зориулалт нэмэгдэж байгаатай уялдан түүний хэмжээ ялангуяа бэлчээрийн талбайн хэмжээ байнга буурсаар байна. Манай орны хөдөө аж ахуйн газрын хэмжээ сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд ойролцоогоор 15 орчим сая га-аар буурсан байна. Хөдөө аж ахуйн газар нь байгалийн унаган төрх байдал, нөөц чадавхаараа харилцан адилгүй тул хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд гүйцэтгэх үүргээр нь бэлчээрийн, газар тариалангийн, хадлангийн, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар гэж хуваагддаг.

Хөдөө аж ахуйн зориулалттай 119 сая га талбай байгаагаас бэлчээрийн талбай 116 сая га, хадлангийн талбай 634 мянган га, тариалангийн талбай 1,1 сая га, атаршсан газар 233 мянган га, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар 106 мянган га, ашиглалт муутай газар 475 мянган га гэсэн ийм байна. Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайланд дурдсанаар улсын хэмжээнд 80 мянган га бүхий өвөлжөө, хаваржааны газрыг 137914 иргэн эзэмшиж байна.

Тариаланд ашиглаж буй нийт талбайн хөрсний 36,2 нь элсэнцэр, 53 хувь нь хөнгөн, шавранцар, механик бүрэлдэхүүнтэй байна. Хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөрсөнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхдээ хөрс хамгаалах технологийг иж бүрэн хэрэгжүүлэхгүйгээс элэгдэж, эвдрэлд тариалангийн газрын хөрсний ялзмагт агуулалт нийтдээ ядуу бөгөөд хөрсний элэгдэл, эвдрэлд нэрвэгдсэнээр ялзмаг агуулгынхаа 7,2-39,4 хувийг алдсан байна.

Бэлчээрийн мониторингийн 2016 оны мэдээллээр мониторингийн бүх цэгийн 42 хувь нь төлөв байдлын хувьд соргог буюу талхлагдаагүй, 13,5 хувь нь сул, 21,1 хувь нь дунд зэрэг, 12,8 хувь нь хүчтэй талхлагдсан, харин 1,3 хувь нь сэргэлтгүй талхлагдсан бөгөөд тариалангийн суурь он буюу 2014

оныхтой харьцуулбал бэлчээрийн талхлагдсан түвшин сүүлийн 2 жил өссөн дүнтэй, талхлагдаагүй болон сул талхлагдсан гэж ангилагдсан цэгийн тоо 10 хувь буурч, хүчтэй болон сэргэлтгүй талхлагдсан цэг 4,3-5,6 хувиар тус тус нэмэгдсэн гэж тогтоогджээ.

2002 онд батлагдсан Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулсан хувийн гэр, орон сууцын хаашаа барих зориулалтаар 0,07 га-аас илүүгүй, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-аас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлэх болно гэж заасан.

Багийн ИНХ-ын санал, сумын ИТХ-ын шийдвэрийг үндэслэн тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамт хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл гэж тус тус заасан байдаг. Дээрх хуулийн заалтаас үзэхэд иргэн төмс, хүнсний ногоо, таримал ургамлын зориулалтаар олгогдох газрын хэмжээ 0,1 га-аас илүүгүй байх бөгөөд зөвхөн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэн 0,1 га-аас илүүгүй хэмжээгээр үнэ төлбөргүй газар эзэмших эрхтэй байна. Өөрөөр хэлбэл иргэн газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажиллаагүй бол 0,1 га-аас илүү хэмжээгээр газар үнэ төлбөргүй эзэмших эрхгүй юм.

Мөн Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт заасны дагуу атар газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглосон тул сум, орон нутгийн иргэд төмс, хүнсний ногоо, таримал ургамал

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тарих зориулалтаар эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалт нь учир дутагдалтай байна.

Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн доройтол, хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын түвшнийг сайжруулахын тулд энэхүү хуулийн төсөл төслийг боловсрууллаа.

2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 7 дугаар сарын 27-ны өдрүүдэд нийт 7 хоногийн хугацаанд томилолт аван өөрийн сонгогдсон тойрог болох Булган аймгийн 9 сум, 1 тосгонд ажиллан сумын өрхүүдээр нийт 10 удаагийн уулзалт хийж, 800 гаруй иргэд сонгогчтой уулзан саналыг авч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах танилцуулга, хууль санаачлагч Бат-Эрдэнэ гишүүн маань хийсэн. Хэлэлцүүлгийн хүрээнд нийт 10 сумын 800 гаруй иргэдийн 60 хувь нь Газрын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэн байна.

2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ди парламент цэг мн сайтаар хуулийн төсөлд олон нийтээс санал авсан бөгөөд санал ирээгүй болно. Хуулийн төсөл батлагдсанаар зардал гарахгүй гэж үзэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Болорчулуун гишүүн, Батжаргал, Идэрбат гишүүнээр тасаллаа. Болорчулуун гишүүн асуултаа асууя.

Х.Болорчулуун: Газрын тухай хуульд бас гишүүдийн санаачилгаар бас нэмэлт, өөрчлөлтүүд нэлээн орохоор хуулийн төсөл боловсруулаад яригдаж байна. Тогтохсүрэн нарын гишүүд бас оруулсан байсан. Одоо энэ Бат-Эрдэнэ нарын гишүүд бас оруулахаар ингэж яригдаж байна. Тэгэхээр намар газрын тухай хууль намрын чуулганаар орно. Энэ дээр нэмэлт байдлаар ажиллах юм байгаа

биз, тийм ээ, орох юм байгаа биз. Тийм, түүнээс тус тусдаа Газрын тухай хуулийг бэлчээрийн хууль юм уу, бусад байгалийн тусгай хамгаалалттай газар нутаг гээд ингээд та салгаж аваад Газрын хуулийг хуульчлах нь буруу гэж үзэж байгаа юм. Тэгэхээр нэмэлтээр орж байгаа явдлыг дэмжиж байна.

Тэгээд Ж.Бат-Эрдэнэ гишүүний хувьд тариалангийн бүс нутгаас сонгогдсон гишүүн болохоор тэнд нэмж газар тариалан эрхлэх хүмүүсийн идэвх санаачилгыг өрнүүлэх хүсэл эрмэлийн дагуу бас саналаа нэлээн боловсруулж оруулж ирсэн юм байна. Тэгээд дэмжиж байна, үүнийг. Ер нь гэхдээ цаашдаа атар газраасаа илүү атаржсан газрыг хагалах дээр илүү би түлхүү анхаарах ёстой юм шүү. Яагаад гэвэл манайх одоо үр тариа гэхэд 340 мянган га тарьж байна. Нийт ногоон тэжээлтэйгээ 440, 50 мянган га тарьж байна. Одоо өшөө атаржсан газрыг социализмын үед ургаж болох бүх газруудыг хөрсний шинжилгээг маш сайн хийсэн байдаг юм. Түүнээс цоо шинэ атрыг яагаад эргээд нөгөө хэсэг хугацаанд юм тариад ургахгүй нь гэсэн байдлаар хаягдах энэ тэр бас болгоомжлол бий болох талтай. Тэгэхээр гэхдээ ерөнхийд нь бас энэ дэмжиж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Болорчулуун гишүүн сайд санал хэллээ. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг манай холбогдох Их Хурлын гишүүд боловсруулж өргөн барьсан байна. Тэгэхээр энэ Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа энэ хуулийн төсөл маань газар тариалангийн газрынхаа харилцаатай холбоотой асуудлыг хөндсөн юм байна гэж ингэж мэдээллээс сая ойлгосон. Тийм учраас ер нь энэ газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нарт ямар боломж олгох тийм

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

эрх зүйн зохицуулалтууд байна вэ гэдэг асуудал 1 дүгээрт чухал байна.

2 дугаарт, бид нар газар тариалангийн талбайн хэмжээ газрын нэгдмэл сангийн ангилалд тодорхой заагдаад орчихсон, угаасаа. Одоо бид нар энэ байгаль цаг уурын хувьсан өөрчлөлттэй холбогдуулаад Хөдөө аж ахуйн нэгдлүүдийн газар тариалангийн зориулалтаар ашиглаж байсан талбайнууд атарших хэлбэр лүүгээ ороод бараг нэлээдгүй хугацаа өнгөрчихлөө. Тэгэхээр тэр талбайнуудад тодорхой газрын хянан баталгаа хийгээд газар тариалангийн зориулалтаар ашиглах тийм бололцоо, боломж, хөрснийх нь бүтэц, үржил шим байна гэж үзвэл тодорхой хэмжээгээр энэ малын тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх бололцоо байгаа юм гэж ингэж харагдаад байдаг. Энэ талаар хөндөгдсөн ер нь ямар заалт асуудлууд байна вэ гэдэг ийм зүйл.

Одоо бид нарын мөрдөж яваа Газрын тухай хуульд тариалангийн зориулалттай газраас давуу эрхээр олгодог 2 л ангилал бий. Олон жил энэ газар тариалангийн салбарт ажиллачихсан тариаланч нарт үр тарианы зориулалтаар 100 га, төмс, хүнсний ногооны чиглэлээр 5 га газрыг давуу эрхээр олгодог нэг л ийм л хэлбэр байгаа. Бусад нь бүгд үндсэндээ дуудлага худалдааныхаа хэлбэрээр олгогддог ийм л зарчим яваад байгаа. Үүн дээр бас тодорхой хэмжээний хөндсөн тийм асуудал байна уу гэдэг ийм зүйл байгаа юм.

Сүүлийн үед бид нар энэ МАА, газар тариалангийн үйлдвэрлэлийн хослолыг хангана гэдэг юм яриад ингээд явцаагаад байгаа улсууд. Тийм учраас газар тариалангийн бүсээ дагуулсан эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийнхөө асуудлыг ер нь бас юу гэж харж тэр эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн тариалалтын чиглэлээр талбайн хэмжээ шийдэх барих чиглэлээр бас энэ өргөн

баригдсан төсөл дотор хөндсөн зүйл байна уу гэсэн ийм хэдэн зүйл дээр тодорхой мэдээлэл авъя гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Ганибал гишүүн хариулъя.

Н.Ганибал: Би энэ хуулийн гол асуудал нь болохоороо ер нь зүгээр малчид, тариаланчид, ногоочид энэ боломжийг л нэмэгдүүлж байгаа юм. Ер нь бид бүхний хувьд өнөөдөр газрын харилцаан дээрх асуудлууд, газар тариалангийн өнөөдрийн хэрэгжиж байгаа хууль дээрээс нь мал аж ахуйн асуудлууд гээд энэ болгон дээр эхний алхмыг л хийх гээд байгаа юм. Бид нар өнөөдөр атаршсан талбайнуудыг эргэлтэд оруулсан. Харамсалтай нь яг улаан буудай гэдэг юм уу голчлоод тэр талынх нь яваад байдаг. Яг таримал тэжээлийн асуудал дээр жил болгон харилцан ингээд адилгүй ургацын байдлаасаа болоод тэр бизнесийг өнөөдөр манай газар тариалангийнхан яг жил болгон тогтмол хийх ийм асуудал бас хийгдэхгүй байгаад байгаа юм л даа.

Тэгээд 2 дахь асуудал нь атаршсан талбайнууд дээр маш их судалгаа хийгдээд харамсалтай нь баахан хүмүүс авчихсан. Тэгээд тэр хүмүүс өнөөдөр хүртэл тэр таримлаа тарьдаггүй ингээд атаршсан хэвээр нь байлгаад нэг 3 жил болгоод тэгээд өөр нэгэн хүнд шилжүүлээд тэгээд бидний өнөө хүсээд байгаа ногоон тэжээлийг маань тарьдаггүй, 1 ААН, 1 иргэн их хэмжээгээр талбай авсан тохиолдолд тэр хүмүүс өөрсдийнхөө нөгөө асуудлыг л шийдээд яваад байгаа юм. Энэ өнөөдөр яг ингээд малчдын хувьд яг хүсэлт боломжит нөгөө яг ногоон тэжээл таримлууд нь таригдахгүй байгаа асуудал байгаа юм л даа.

Тэгэхээр энэ удаагийнх зүгээр жсоохон бага хэмжээгээр нэмээд бид нарын дараагийн шилжих асуудал мэдээж өнөөдрийн бэлчээрийн МАА бол эрчимжсэн Мал аж ахуйтай хосолж

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

цаашаа явах эхлэлийн суурийг л бага хэмжээгээр нэмэгдүүлээд тэнд боломжуудыг нь тавьж өгч байгаа юм. Магадгүй говийн малчин бол 1 га дээр юу тарих вэ гэдэг асуудлууд ч өнөөдөр тэр нь асуудлууд яригдах байх л даа. Тэгэхдээ өнөөдөр дэлхий нийт дээр говь цөлийг тарималжуулах, тэр дуслын систем гээд олон туршиллагууд байгаа. Тэгээд энэ болгоныг бид нар нутагшуулахын тулд эхний ээлжид өнөөдөр байгаа нэг га-г нь 1,5 болгоод энэ боломжийг нь нэмэгдүүлээд тэр технологиудыг суурилуулах тэр эхлэлийг л тавиулахын тулд үүнийг хэмжээг нь томсгож байгаа. 0,5 дээрээ өвөлжөөгөө, хаваржааг юм уу аль нэгийг нь сонгоод байшингаа барьдаггүй, хаашаага барина биз. 1 га дээрээ бид нар нэмэлт боломжуудыг нь хийж өгөх ийм л зорилготой хууль байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Би өшөө нэг жоохон нэмэлт тодруулчих уу. Батжаргал гишүүн ээ. Энэ 2 заалт орж ирж байгаа юм. Таны хэлсэнчлэн нөгөө ногоон тэжээл тариалах, малчдын мал маллагаанд бас нэмэр тус болох гэсэн утгаар орж ирж байгаа юм. Тэгэхээр 1 заалт нь иргэнд хувийн гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан 1 удаа үнэ төлбөргүй эзэмших газрын хэмжээ хувийн гэр орон сууцын зориулалтаар 0,07 байгаа шүү дээ, 0,07 га.

Өвөлжөө, хаваржааны зориулалтаар 1,5 га-аас тус тус илүүгүй байна гэсэн ийм заалт орж ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ дээр шинээр өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар олгож байгаа газар нь 1,5 га-аас илүүгүй байна гэж байгаа юм. Энэ нэг заалт. Энэ нь Газрын тухай хуулийн 29.1 дэх заалтад ийм өөрчлөлт оруулж ирж байгаа юм.

2 дахь заалт нь энэ дотроо Газрын тухай хуулийн 29.4 дээр 4 гэж заалт оруулаад энэ хуулийн 52.7-д заасан өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшиж буй иргэн эзэмшсэнийхээ

1 га хүртэлх газартаа гэр бүлийн хэрэгцээнд зориулж төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалж болно гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл өвөлжөө, хаваржааны газар нь 1,5 га байна, илүүгүй байна. Үүн дотроо 1 га-г нь төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалж болно гэж байгаа юм. Ер нь юуны хуулиар Тариалангийн тухай хуулиар атар газар бид нар чинь хагалж болохгүй шүү дээ. Тэгэхээр ер нь өвөлжөө, хаваржаа дээрээ байгаа газраа эргэлтэд оруулах 1 га-г нь өөрсдийнхөө хувийн хэрэглээнд ашиглах ийм боломж бололцоог нь олгож байгаа юм. Үүн дотроо таны хэлсэнчлэн малчдын ахуй амьдрал болон мал маллагаа дээр нь тус дэм болох тариалангийн ургамал тариалах, тэр тусмаа бид нар чинь сүүлийн үед хот хөдөөгийн шинэчлэл гэсэн том хөтөлбөр явагдаж байгаа шүү дээ? Тийм. Энэ хүрээнд магадгүй хотоос очсон хүмүүс маань өвөлжөө хаваржаан дээрээ хүнсний ногоо тариалах, дээрээс нь жимс жимсгэнэ тариалах гээд аж ахуй өөрсдөө эрхлэх ийм боломж бололцоог нь нээсэн ийм хуулийн заалт орж ирж байгаа шүү.

Дараагийнх нь Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Ер нь Газрын тухай хуулийг Засгийн газраас өргөн бариад тодорхой хэлэлцүүлгүүд явагдаж байгаад эргүүлээд татчихсан. Тэгээд Газрын хууль хориод жил бас ийм шинэчилсэн найруулга ороогүй, нэлээн асуудлууд хуримтлагдчихсан ийм зүйл л дээ. Тэгээд сүүлийн үед энэ газартай холбоотой үндсэндээ бараг 4 асуудал, 4 хуулийн төсөл яригдаад байх шиг байна. 1 дүгээрт, энэ хуулийнх байна. 2 дугаарт, Тогтохсүрэн, Батжаргал тэргүүтэй гишүүдийн өргөн барьсан хууль байна. 3 дугаарт, энэ хөрөнгө оруулалтын хуулийн асуудал гээд түүн дээр бас нэг газрын асуудал. 4 дүгээрт нь нөгөө нэг СӨХ-ийн орон сууцын доод газар гээд. Ингээд үндсэндээ Улсын Их Хурал дээр ингээд нэг

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

4 газрын асуудал л яригдах гээд байна л даа.

Өнөөдөр энэ манай Байнгын хороо дээр яригдаж байгаа энэ асуудал дээр бас нэлээн бодолтой хандахгүй бол би болохгүй ээ гэж ингэж бодож байгаа юм. Одоо энэ чинь нэг 2 ойлгомжгүй юм явагдаад байгаа юм. Яг амьдрал дээр. Юу гэхээр өвөлжөө, хаваржаа дээрээ олон наст ургамал тарьж байна гээд л зөв гээд л үүнийг нутагишуулах хэрэгтэй гээд л нэг ингээд явж байх. Нөгөө талдаа Барилга, хот байгуулалт, геодези зураг зүйн газрынхнаас үүнийг тодруулахаар энэ болохгүй ээ гээд байдаг. Нэг ийм ойлгомжгүй юм байгаад байгаа юм л даа. Тэгэхээр үүнийг л нэг чигт нь болгох гээд байгаа юм болов уу л гэж ингэж би хараад байна л даа.

Жишээ нь Өвөрхангайд бол болоод тариад байна гээд өчигдөрхөн ТВ 5-аар гарч байх шиг байна лээ. Манай Хэнтий аймагт энэ атаршсан газар биш учраас энэ дээр тариа ургамал тарьж болохгүй ээ, тариалангийн хуулиараа хориотой гээд ингээд байдаг юм. Тэгэхээр ер нь яах вэ 1,5 га гэдэг бас нэлээдгүй том талбай. Энэ дээр юм тарина гэдэг чинь тодорхой хэмжээнд хөрөнгө оруулалт орно. Тэгээд бид нар яг малын бэлчээр дээр энэ чинь бараг таригдчих гээд байна шүү дээ. Өвөлжөө, хаваржаагаа тойруулаад. Тэгэхээр хашаад эхлэнэ, хүссэн хүсээгүй хашна. Ингээд л нөгөө нэг бэлчээр хаших барих ийм маргаан мэтгэлцээн рүүгээ ороод л буруу тийшээ явчих вий дээ гэсэн нэг ийм надад ийм болгоомжлол. Тэгээд хууль санаачлагч нар энэ дээр бас яаж харж байгаа юм бол, яаж харж байгаа юм бол. Бэлчээрээ хашаад л эхлэх юм энэ чинь тэгээд л 1,5 га нь өшөө томроод л эсвэл өвөлжөөн дээрээ 1,5-тай, хаваржаан дээрээ 1,5-тай, үр хүүхдийнхээ нэр дээр авсан түүн дээрээ хашна гээд л ингээд л хашаажсан л юм болох вий дээ гэсэн надад ийм л болгоомжлол байгаа.

Яах вэ, зүгээр цаашидаа энэ Газрын хууль намраас Засгийн газар өргөн барих байх. Гэхдээ одоо өргөн баригдчихсан байгаа энэ газрын асуудлууд дээр хамтатгаад хэлэлцээд явах байх гэж ингэж л бодож байна. Тэгэхээр энэ хаших талын асуудлыг энэ дээр ер нь яаж харж оруулж байгаа юм бэ? Зүгээр эзгүй тал дээр юм тариад тэр нь ургана гэж бол ургах нь ургах байх. Тэгэхдээ л харуул хамгаалалтын асуудлууд байгаа шүү дээ. Энэ дээр би хууль санаачлагчдаас тодруулга авъя гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Би хариулчих уу? Ийм юм, Идэрбат гишүүн ээ. Энэ манайхан нөгөө ойлгохдоо яах вэ, зүгээр анх хууль санаачилж байх үедээ 1 хүртэл га газраа малчин болон иргэн эзэмшигч гэж байгаа юм, тэгэхээр энэ хуульд оруулж ирэхдээ газрын харилцааныхантай яриад ерөөсөө өвөлжөө, хаваржааны газар өөрөө 1,5-аас илүүгүй байна гэж оруулаад байгаа юм. Өвөлжөө, хаваржааны газар. Тэгэхээр энэ чинь өөрөө таны өвөлжөө байна, байшин байна, пүн пин байна. Тэнд нэг бууц юу байдаг юм жорлон, хашаа хороо энээ тэрээ гээд энэ хязгаар чинь өөрөө 1,5 байхгүй юу, 1,5. Бидний өвөлжөө, хаваржаагаа амьдарч байгаа газар маань өөрөө 1,5. Үүн дотроо гурвалжин байна уу, дөрвөлжин байна уу 1 га-д нь таримал ургамал болон жимс жимсгэнэ, хүнсний ногоогоо өөрсдөө тарьж, өөрсдийнхөө амьжиргаанд хэрэглэе л гэж байгаа байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл газраа эргэлтэд оруулж байгаа юм. Түүнээс биш тэр уулын аманд ч юм уу, хаа нэг газар аваачаад тарьчихгүй. Тэр өвөлжөө, хаваржаанаасаа цаашаа хэтрүүлээд тарьчихгүй, өөрийнхөө хязгаар 1,5 дотроо 1 га-г нь л ашиглая л гэж байгаа байхгүй юу. Ашиглуулъя гэж байгаа юм. Тэгэхээр энэ гарахгүй цаашаагаа. Хот байгуулалтынхантай, газрынхантай бид нар ярьж ярьж байгаад ерөөсөө малчдынхаа өгч байгаа өвөлжөө, хаваржаа нь аль 1 дээр гэж байгаа шүү, бүгд дээр нь биш бас өрх тийм үү, өвөлжөө хаваржаатай байвал аль нэг

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

дээр нь шүү. Аль ургах бололцоотой байдаг юм уу, аль нэг газар дээрээ л жишээ нь иргэн Бат-Эрдэнэ гэж байгаа бол өвөлжөө, хаваржааныхаа аль нэг дээр 1 удаа гэж байгаа шүү. Энэ нэг удаа үнэ төлбөргүй эзэмшүүлэх гэж байгаа юм шүү. Тийм. Зуслан биш өвөлжөө, хаваржаа дээрээ л тавья. Тэгж байж одоо бол жишээ нь таны хэлдгээр тариалангийн тухай хуулиар үнэхээр үнэн. Яагаад гэхээр хагалж болохгүй байхгүй юу, бид нар. Тийм болохоор үүнийг нь нээгээд энэ дотроо 1,5-ыг нь л эзэмших ийм бололцоог нь нээгээд өгчхөж байгаа юм шүү. Тийм.

Ганибал гишүүн. Ганибал гишүүний микрофоныг нээе.

Н.Ганибал: Ер нь Идэрээ гишүүн ээ, хэдүүлээ ер нь газрын нөгөө нэг Тогтохоо гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Батжаргал гишүүнээрээ өргөн барьсан. Бид хэд чинь бүгдээрээ өргөн барьчихсан байгаа шүү дээ, 26, 7 хүн. Тэгээд дээрээс нь үүнийг нэмнэ.

Ингээд хэдүүлээ ер нь бүр маш сайн хэлэлцүүлгүүдийг хийгээд нэг тийм уламжлалт нэг айдсууд байгаа шүү дээ, тэд нараасаа бид нар салах ёстой. Ямар бүгдийг нь бэлчээрийг ингээд хаших гээгүй шүү дээ. 1 га-г бол хашина, хашиж байж тэнд чинь таримлаа тарина, хашиж байж тэнд ногоогоо ургуулна. Хашиж байж тэнд тэр жимс жимснийхээ модыг тарих байхгүй юу. Тэгэхгүй мал идчих байхгүй юу. Зүгээр ингээд тал дээр юу гэж ямар нэгэн юм тариад хашихгүй бол тийм, тийм өвөлжөө, хаваржаагаа хашихаад хагас суурьшмал бэлчээрийн МАА руу бид нар шилжих гээд байна шүү дээ. Энэ зүгээр үүнийг дагаад маш олон өөрчлөлтүүд орж ирнэ л дээ зүгээр. Одоо бид нар зүгээр өвөлжөө, хаваржааныхаа газрыг зүгээр кадастраар хийлгэхээд байгаа шүү дээ. Үүнийгээ л тодорхой хэмжээнд эзэмшлийнхээ, хашина гэдэг чинь өөрөө түүн дээр юмаа тарих гэж л хашиж байгаа болохоос тэрэнд нэг хашигуутаа дотор нь ороод гарахгүй

байгаа асуудал биш байхгүй юу. Ийм л асуудал байгаа.

Ер нь зүгээр цаашид Газрын тухай, Бэлчээрийн тухай хуулиуд дээр бид нар оролцоод ингээд явахаар хэд хэдэн аягүй чухал асуудлууд гарч ирнэ. Ус цэгийн асуудлууд тийм ээ, энэ худаг эзэмшиж байгаа бол энэ худага дагаад л амьдрал явдаг. Тэгвэл өвөлжөө, хаваржаа дээрээ бид нар тодорхой хэмжээнд ашиглах энэ боломж нь нээгдвэл тэрийгээ дагаад бид бас амьдрах ёстой юм. Өнөөдрийн бид нар өвөл жоохон 1 га-д нэг жижигхэн л дээ. Бага хэмжээнд бид нар ногоон тэжээл тарьчаад өвөл төл малуудаа бүгдийг нь оруулаад өвөлжүүлчихэд ер нь хавар ч юм уу аль нэгэнд нь ашиглах нь малчин өөрийн сонголт. Тэгэхэд тэнд байгаа ургамлаа, ногоон тэжээлээ идээд тэндээсээ хашаанаасаа гаргахгүй байж чадвал бид нар өнөөдрийн өвлийн тэр эрсдэлүүдийг даван туулах, хаврын тэр эрсдэлүүдийг даван туулах энэ боломжийг бид нар бага хэмжээгээр нээж өгч байгаа.

Цаашилаад бид нар өнөөдрийн бэлчээр талхлагдсан. Өнөөдөр бид нарт малын тоо толгой бэлчээрийн даацаасаа хэд дахин хэтэрсэн энэ цаг хугацаанд бид нар зөвхөн байгаа бэлчээрээ ашиглах, сэлгэхээс гадна бид нар ургаж, тарималжуулж, бэлчээрийг бий болгохгүй бол өвс тэжээлээ бий болгохгүй бид нарын нөгөө боломж мухардалд орчихоод байгаа байхгүй юу. Үүний бас жижиг эхлэл гээд ойлгож болно.

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат гишүүн тодруулах уу.

Ц.Идэрбат: Тийм ээ. Ер нь яах вэ бэлчээрийн аж ахуйг цаашаа хөгжүүлэх үү яах вэ гэдэг дээр бид нэг тодорхой шийдэлд хүрэхгүй бол байгаль угаасаа бид нараас тодорхой шийдэл нэхэж байгаа л даа. Тийм, тийм, байгаль угаасаа шахаж байгаа. Тийм учраас яах вэ хэлэлцэх эсэх дээрээ дэмжигдээд тэгээд 2 газрын хуулиа хооронд нь ажлын хэсгүүд нь

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

уялдуулаад ингээд л явах болох байх. Тэгэхдээ яах вэ зүгээр миний хувьд ингээд болгоомжлоод асуугаад байгаа юм бол бас л яг нөгөө Тогтохсүрэн, Батжаргал гишүүн нарын өргөн барьсан бид бүхний өргөн барьсан хуулийн хэлэлцүүлгээр нэлээн явсан л даа. 100 гаран 200-аад хүнтэй Хэнтий, Дорнод, Сүхбаатар гээд ингээд явсан. Тэр хуулийн маань үзэл баримтлалтай энэ бас нэлээн суурь зарчмаараа жоохон зөрчилдөх гээд байгаа байхгүй юу. Тэр өвөлжөө, хаваржааг тийм байран суурин биш, багийн хурлаараа хэлэлцдэг ярьдаг ийм юм руугаа орё энэ тэр гээд ингээд. Тэгэхээр яах вэ өнөөдөр яах вэ, Байнгын хороо дээр хэлэлцэх эсэхээ шийдээд тэгээд 2 энэ газрын бэлчээртэй холбоотой энэ 4 хууль өргөн баригдах өөрчлөлт ... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Тогтохсүрэн гишүүнтэй яриад ер нь бас Энхбаяр гишүүний өргөн барьсан хууль байгаа. Ингээд 3 хуулийг нэгтгээд ер нь Газрын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа 3 хууль санаачилсан байж байгаа. Үүнийгээ нэгтгээд 1 ажлын хэсэг болгоод явчихъя гэж байгаа шүү.

Болорчулуун сайд микрофоныг нээе.

Х.Болорчулуун: Ер нь манай малчид бас яг МАА эрхлээд хажуугаар нь газар тариалан эрхэлж чаддаггүй л дээ. Өөрөө цагийн хөдөлмөрийнх нь нөхцөл байдал ч яг тийм бас зав чөлөө их муутай болохоор их хэмжээгээр 1,5 га дотроо хэдийг ч тарьж болох нь байна шүү дээ. Та тийм өөрийнхөө боломжоор тарих нь байна. Тэгэхдээ бас эрхийг нь ингээж олгож байгаа боловч үүрэг хариуцлагыг нь бас давхар тэр хууль дээр зааж өгөх ёстой. Яагаад гэвэл энд тэндгүй малчид манай өвөлжөө гэнгүүтээ баахан газар хашигнуудаа хагалаад тэгээд сүүлд нь энэ чинь дандаа өвөлжөө дээрээ байхгүй, хаваржаа дээр байхгүй шүү дээ. Орхиод явдаг, нүүдлийн МАА гэдэг чинь. Тэр газар нэг газар удаж чадахгүй. Тэгэхээр хэрвээ

хагалчхаад тариалахгүй тохиолдолд тариалж хагалчхаад тариалаад хаягдуулсан тохиолдолд олон наст энэ тэр ургамал тарьж орхих тийм эрх зүйн орчныг нь нээж, үүрэгжүүлж өгөхгүй бол баахан энд тэндгүй шарилж ургасан, хагалсан газар байгаль орчин сандайлгаад явчих вий. Та нар хөдөөгүүр явж байхад айлын өвөлжөө, хаваржаа байсан ингээд зэрлэгтэй газрууд зөндөө л байгаа шүү дээ. Байдаг шүү дээ, тийм болох вий гэдэгт бас болгоомжлоод байна шүү. Тэгээд ажлын хэсэг дээр бас сайн ярьсан нь зүйтэй гэдгийг бас хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. Батжаргал, Бейсен гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Ганибал гишүүний гаргаж байгаа саналыг дэмжиж байгаа юм. Бид нар бүгдээрээ л хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд. Бэлчээрийн МАА бас тодорхой хэмжээнд суурин байдал руу шилжихэд бас хөшүүрэг болсон ийм заалт байж байгаа. Одоо хэлсэн хэлээгүй үндсэндээ зарим арчаатайхан малчид энэ тэр бол хаваржаа, өвөлжөө дээрээ багахан газар төмс ногоогоо тариалах, олон наст ургамал тариалах, тэжээлийн бага ч гэсэн газар тэжээлийн ургамал тариалах байдал ажиглагдаж байгаа. Тийм учраас энэ заалт байх нь зөв.

Бэлчээр хашиажуулах асуудал яах вэ, бас ажлын хэсэг дээр бас дахиад ярилцацгаах нь зөв байх. Ялангуяа энэ тэжээлийн ургамал тариалах явдал элбэг болж байна. Яагаад гэхээр сүүлийн хэдэн жил үндсэндээ гантайдуу өвс хадлан тааруухан байсан. Тэрний оронд байгалийн хадлангаасаа илүү таримал ургамлыг бага газраас их хэмжээний бас тийм ногоон тэжээл авчих бололцоо бий. Үүнийг нь дэмжих ёстой хөшүүрэг бол яах аргагүй энэ сая Ганибал гишүүний гаргаж байгаа санал зөв өө. Тийм учраас энэ

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

заалтыг дэмжээд явах нь зөв байх гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжье. Тэгээд энэ Хөдөө аж ахуйн газрын харилцаа зохицуулж байгаа тэр хуулийн төслүүдтэйгээ уялдуулаад нэгтгээд аваад явах нь зөв гэж ингэж ойлгож байна.

2 дахь асуудал ерөөсөө л ийм л зүйл л дээ, энэ чинь. Малын өтөг бууц, малын хөлөөр газрынхаа релетийг дагаад тийм үүсмэл хөрс бий болгочоод байгаа байхгүй юу. Тэрийгээ Монголчууд бууцны хөл гээд яриад сурчихсан. Түүн дээрээ малын тэжээлийн ургамал тариад байгаа. Өвөрхангайд ч бий, Төв аймагт ч бий. Ер нь манайд тариалан эрхэлж байгаа бас байгалийн хадлан авах боломж муутай бүс нутгийн сумуудад эхлэл байгаад байгаа юм. Үүнийг бид дэмжих ёстой. Энэ газар хагалдаггүй, яг нарийндаа бууцны хөлийн хөрсийг бараг энгийн хэллэгээр бол савраар мөр гаргаж татаад тэгээд түүн дээрээ үр цацаад буцаагаад бууцаар нь булчихдаг. Тэгээд л тодорхой хэмжээний ургац авчихдаг ийм л зүйл шүү дээ. Их энгийнээр хэлэх юм бол. Тэгэхээр үүнийг бид дэмжих ёстой. Яг ингэж ургац өгч болохоор газруудад атар хагалахгүйгээр, тэр үүсмэл хөрсөн дээр малын тэжээлийн ургамал буюу тэр таримал тариад хурааж авах бололцоо, боломжийг нь эрх зүйн хувьд их зохистой хязгаарлалттайгаар нээж өгөх явдал 1 дүгээрт асуудал байх ёстой гэж ингэж ойлгоод байна.

2 дахь зүйл, ерөөсөө хүн өөрийнхөө эзэмшлийн газар дээр хөрс, газар, хөрсний доройтол янз бүрийн юм үүсгэчихгүйгээр аж ахуйнхаа өрхийнхөө хэрэгцээнд зориулаад таримлууд тарьдаг. Хүнсний ногоо, төмсөө тарьчихдаг. Энэ боломжийг нь хуулиар бид нээгээгүй ч гэсэн өнөөдөр яваад л байгаа зүйл.

Ерөөсөө бүгд, төв суурины айл өрхүүд ч өөрийнхөө 0,07 гэдэг юм уу, өнөө 0,5 га дотроо нэг буланд нь байцаа ч, сонгино ч, төмс ч бүх л юм хийгээд яваад байгаа. Зүгээр үүнийг хэдүүлээ энэ нэгэнт хөндсөн юм, энэ хуулиар ер нь эрх зүйн хувьд нь эргэлзээгүй болгоод ямархуу байдлаар зохицуулж өгч болох юм гэдгийг мэргэжлийн улсуудаасаа бас нэлээн санал бодлыг нь сонсоод тэгээд хуульчлаад өгчихөд нэг их буруудаад байх юм байхгүй. Өөрийнхөө эзэмшил газар дотроо багтаад тэгээд өөрийнхөө ахуй амьдралыг дээшлүүлэх, өрхийнхөө хүнсний хэрэгцээг нэмэгдүүлэх, хангах чиглэлээрээ ийм юм бол тэртээ тэргүй манай энэ бүс нутгуудад айл болгон хийгээд явж байгаа зүйл ээ.

Үүнийг нь зөв зохистой бас шийдчихэд нэг их буруу зүйл байхгүй болов уу гэсэн ийм бодолтой байна. Ийм л санал байна.

Ж.Бат-Эрдэнэ: Бейсен гишүүн саналаа хэлье.

Б.Бейсен: Энэ аймаг дундын отрын бүсийн талаар ярья гэж бодож байна л даа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн асуудал байгаа, тийм.

Б.Бейсен: Тусдаа юм уу. Хадлан.

Ж.Бат-Эрдэнэ: Газрын тухай хууль, тийм. Одоо бол Газрын тухай хууль.

Тэгвэл би бас нэг хэдэн зүйл хэлчихье. Энэ Батжаргал гишүүн ээ. Одоо бид нар өөрсдийнхөө тэр нөгөө нэг бууцныхаа тэр хөлд эд нар тариалан тариад байна шүү дээ, тийм үү. Эсвэл нэг өөрсдийнхөө 0,7 дээр ч юм уу тодорхой хэмжээнд газар хагалаад байгаа юм. Гэхдээ энэ маань яг хуулиар зөвшөөрөгдөөгүй зүйл байгаад байгаа юм шүү дээ. Энэ атар газар хагалахыг зөвшөөрөлгүйгээр хагалж болохгүй гэсэн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ийм хуулийн заалттай, Тариалангийн тухай хууль дээр байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар нөгөө та хэллээ шүү дээ. Нөгөө Өвөрхангай ч тэр, Архангай ч тэр ганц нэг 2 тариад байна гэдэг чинь өөрийнхөө хаашаан дотор тарьчхаад байгаа юуны малынхаа саравчны хаашаан дотор тарьчхаад байгаа юм. Тэгэхгүй хаашаанаас гаргаад ингээд хажуу талд нь нэг газар хагалах юм бол хуулиараа зөвшөөрөгдөхгүй болчихоод байгаа байхгүй юу. Хорьчихоод байгаа юм. Тэгэхээр үүнийгээ I дүгээрт, өвөлжөө, хаваржаа нь өөрөө гурвалжин байна уу, дөрвөлжин байна уу, II хэлбэртэй байна уу, I хэлбэртэй байна уу, энэ өөрөө I,5 га байг. Өөрөөр хэлбэл өвөлжөө, хаваржаагаа ингэж эзэмшиг. Үүн дотроо дахиад II хэлбэртэй байна уу, гурвалжин хэлбэртэй байна уу тэр хаашааны булангаас ингэж ингэж байна уу. I га газартаа л тариалан хүртэл газартаа л тариалан тариалах хүнсний ногоо болон жимс жимсгэнэ тэгээд тэжээлийн ургамал тариалах боломж бололцоог л нээгээд өгчхөж байгаа юм. Өөрөөр хэлбэл өрхийн үйлдвэрлэл явуулах боломжийг нээгээд өгчхөж байгаа юм. Гэхдээ I удаа гээд хаа сайгүй удаа хагалчих биш өрх, өвөлжөө, хаваржааныхаа аль нэг дээр нь гэж ингэж тодорхойлж өгч байгаа юм шүү.

Тэгэхээр гишүүдийн хэлсэнчлэн Энхбаяр гишүүний өргөн барьсан Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах нэг хууль байгаа. Тогтохсүрэн болон Батжаргал болон бусад гишүүдийн хүрээнд бас бид нар чинь өөрсдөө бараг л бүгд гишүүд шахуу орсон байх. Энд байж байгаа гишүүд маань бүгд орсон байх. Тэгээд энэ хуультай нийлээд 3 хууль байгаа. Энэ 3 хуулиа нэгтгээд ажлын хэсэг болгоод ингээд хэлэлцээд явуулчихъя гэж.

Ингээд санал хэлж. Тэгэх байх, тийм. Тийм болохоор үүнийгээ хэлэлцэх явцад угаасаа газар тариалан эрхлэх боломж бололцоогүй үед бол энэ чинь хүн амьтан хагалаад байхгүй нь ойлгомжтой боломжтой гэсэн байдлаар үзэж байгаа юм. Тэгээд хэлэлцүүлгийн явцад хэдүүлээ

бас ярья. Түрүүн энэ хэн Болорчулуун гишүүн бас хэллээ шүү дээ, сайд хэллээ. Хэрвээ ингээд хаячхаад явчих юм бол бас хэрвээ хаях тохиолдолд магадгүй зүгээр өшөө нэг заалт оруулж ирээд тэрийг хариуцлагын асуудал, магадгүй зүгээр тэжээлийн тийм, одоо хаядаг өвөлжөө, хаваржаа ч байхгүй болсон доо, ер нь бол тийм.

Ингээд гишүүд санал хэлж, хуулийн танилцуулгатай холбоотойгоор үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ганибал гишүүн танилцуулах уу. Идэрбат гишүүн танилцуулах уу? Идэрбат гишүүн танилцуулъя.

15.27 цаг

Дараагийн асуудал.

Байнгын хорооны тогтоолын төсөл.

**“Ажлын хэсэг байгуулах тухай”
Байнгын хорооны тогтоолын төсөл
хэлэлцэнэ.**

Байнгын хорооны тогтоолын төслийг би танилцуулчих уу.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааныг хэлэлцүүлэгт бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ, гишүүд Т.Аубакир, Б.Бейсен, Ц.Идэрбат, Ц.Туваан нарын гишүүд.

2. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн зүй, туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтнуудыг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг Ж.Бат-Эрдэнэ зөвшөөрсүгэй.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг.

Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

15.29 цаг

4 дүгээр асуудал.

Байнгын хорооны тогтоолын төсөл

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт 1 асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн

төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатанд нэгтгэн 1 төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 5 гишүүнээс 2021 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 22 гишүүнээс 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 5 гишүүнээс 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр тус тус Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг төсөл санаачлагчдын зөвшөөрснөөр нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах гэж байна.

Ингээд тогтоолын төслийг танилцуулъя, та бүхэнд.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 22 гишүүнээс 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 5 гишүүнээс 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 5 гишүүнээс 2021 оны 10 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

15.33 цаг

5 дахь асуудал.

Аймаг дундын отрын бүс нутгийн нөхцөл байдлыг судалж, Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсьё.

Ажлын хэсгийн ахлагч Г.Тэмүүлэн, гишүүд Ж.Батжаргал, С.Ганбаатар, Н.Ганибал, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир, Б.Жаргалмаа нарын Улсын Их Хурлын гишүүд.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Ц.Идэрбат гишүүн танилцуулна. Идэрбат гишүүний микрофоныг нээе.

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтнуудыг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг гээд Г.Тэмүүлэнд зөвшөөрсүгэй.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор аймаг дундын отрын бүс нутгийн нөхцөл байдлыг судалж, Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Батэрдэнэ, Г.Ганболд, Г.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, Т.Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэй ажилласан.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг.

Тогтоолын төсөлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсэг 2023 оны 06 дугаар сарын 12, 19, 21, 28, 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд хуралдаж, ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн удирдлагууд болон отрын бүс нутгийн холбогдох байгууллагын хүмүүстэй уулзаж, аймаг дундын отрын бүс нутгийн нөхцөл байдлын талаар танилцаж, тодорхой үүрэг, чиглэл өгч ажилласан.

Санал хэлэх гишүүд. Алга байна.

Санал хураалт. Тогтоолын төслийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Миний энэ төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин явуулж өгнө үү.

Нэг. Одоогийн нөхцөл байдал.

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат гишүүний хүсэлтээр саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Мал сүргийг байгалийн давагдашгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор 783,3 мянган га газрыг Засгийн газрын тогтоолоор аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан. Улсын тусгай хэрэгцээний нутаг буюу аймаг дундын

54,5 хувиар санал хураалт хүчингүй боллоо. Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ. Тогтоол батлагдлаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

отрын 9 бүсэд 783,3 мянган га талбайд 294 өвөлжсөө, хаваржсаа, өвс, тэжээлийн 7 агуулах, малын 29 хороо, 80 инженерийн хийцтэй худгийг ашиглан үйл ажиллагаа явуулж байна.

Өнөөдрийн байдлаар Хэнтий аймагт 192,8 мянган га талбайтай Хэрлэнбаян-Улааны отрын бүс, Говьсүмбэр аймагт 73,1 мянган га талбайтай Малхын отрын бүс, Завхан аймагт 68,3 мянган га бэлчээрийн талбайтай Бага хайрхан отрын бүс, Говьалтай аймагт 118,6 мянган га талбайтай Аргалантын отрын бүс, Дорнод аймагт 124,4 мянган га талбайтай Чойбалсангийн отрын бүс, Булган аймагт 34,1 мянган га талбайтай Чилэнгийн отрын бүс, Өвөрхангай аймагт 37,9 мянган га талбайтай Хөх дэлийн отрын бүс, Увс аймагт 28,9 мянган га талбайтай Ачит нуурын отрын бүс, Ховд аймагт 105,2 мянган га талбайтай Баяннуурын отрын бүсийг тус тус ажиллуулж байна.

Эдгээр аймаг дундын 9 отрын бэлчээрийн ашиглалт хамгааллыг нь ХХААХҮЯ-ны харьяа Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа хариуцан ажиллаж байгаа бөгөөд захиргааны төв нь Булган аймгийн Дашинчилэн сумд байрлаж, 24 орон тооноос захирал, хуулийн зөвлөх, малын эрүүл мэнд хариуцсан өвс тэжээл, худаг ус мэдээллийн ажилтан, нягтлан, нярав, бичиг хэрэг гэсэн 20 ажилтантай ажиллаж байгаагаас 3 мэргэжилтнийг Дашинчилэн сумаас томилсон байна.

Захиргааны жилийн төсөв нь 423 сая төгрөг, дундаж цалин 800 мянган төгрөг, сарын шатахууны зардалд 300 мянган төгрөг, томилолтын зардалгүй үйл ажиллагаа явуулж байна. Автомашин 4 байгаагаас Хэрлэнбаян-Улаан, Баяннуурын отрын бүсэд тус бүр 1 фургон, захиргаанд бага болон дунд оврын суудлын автомашин ашиглаж байна. Отрын 7 бүс нутаг хяналт тавих унаагүй. Сардаа 1, 2 удаа хувийн

унаагаараа тухайн бүсээ тойрч ажилладаг, байцаагчийн эрхгүй тул албад шаардлага өгч хариуцлага тооцож чадахгүй нөхцөл байдалтай байгаа юм.

Отрын бэлчээрийн даацад тохирсон малыг жил бүрийн 11 дүгээр сарын 11-ний өдрөөс дараа оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл нийт 150 хоногоос хэтрэхгүй хугацаанд нутаглуулахаар орон тооны бус зөвлөлөөр шийдвэрлэж, зун, намрын улиралд мал оруулахгүй чөлөөлөх арга хэмжээ авч ашиглалт хамгаалалтын ажлыг зохион байгуулан ажилладаг байна. Гэвч гаднаас ирсэн оторчид хугацаандаа гарахгүй байгаагаас өнөөдөр Чилэнгийн бүсэд гэхэд 9 өрх байгааг хяналтын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн бол Хэрлэнбаян-Улаанд 38 өрх ажиллаж байгааг ажлын хэсэг ажиллах үеэр тухайн орон нутгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан албадан гаргахаар болсон юм.

Худаг усаа малчдад хариуцуулсан тул худага дагаад газраа чөлөөлдөггүй. Бэлчээрийн ургамал тариалах үргүй. Өвсний саравч нь стандартын шаардлага хангахгүй зэрэг олон дутагдлууд бас байна.

Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутгуудад 2022-2023 онд 12 аймаг, 46 сум, нийслэл, дүүргийн 673 өрхийн хонин толгойд шилжүүлснээр 590,8 мянган толгой мал отрын бүс нутгуудад өвөлжиж, хаваржсан гэсэн албан мэдээ байгаа болов чиг яг бодит байдал дээр энэ тоо дахиад 30-аад хувиар нэмэгдэх юм.

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор малчид орон нутгийн засаг захиргааны хүсэлтийг харгалзан зөвшөөрөлгүй орсон мал сүүгийг бүс нутгуудад өвөлжүүлж хаваржуулсан бөгөөд хаваржилтын хүндрэлтэй байдлыг харгалзан отрын бүс нутгийг малын хөлөөс чөлөөлөн гаргах хугацааг 1 сараар сунгаж, малчид орон

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нутгийн захиргаатай бас хамтран ажилладаг юм байна.

Бэлчээрийн төлөв байдал

Ус цаг уур орчны судалгааны мэдээллийн хүрээлэн, судлаачдын баг Монгол орны цөлжилтийн аатал боловсруулах ажлыг БОАЖЯ-ны захиалгаар 2021 онд хийж гүйцэтгэсэн ба Монгол орны цөлжилтийн зургийг 2020 оны байдлаар боловсруулж гаргасан байна. Аймаг дундын отрын бүс нутгийн цөлжилтийн байдлыг эдгээр нутгийн хил заагаар таслан авч нарийвчлан гаргасан мэдээллийг хавсаргасан.

Отрын бүс нутгуудад цөлжилтөд хамгийн их өртсөн нь Аргалант, Чилэн, Малх, Хөх дэл нутгууд бөгөөд ихэнх нутаг нь цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд байна. Харин Чойбалсан, Бага хайрханы отрын бүс нутгаар цөлжилтийн зэрэглэл хамгийн бага байгаа бол Хэрлэнбаян-Улаан дунд зэрэг болон сул зэрэглэлд, Баяннуруу бүсийн ихэнх нь нутаг сул гэсэн зэрэглэлд байна.

Отрын ихэнх бүс нутагт цөлжилт нэлээд хүчтэй илэрч байгаа нь нэн даруй малын хөлөөс чөлөөлөн өнжсөөх, бэлчээрийн ургамлын өсөлт хөгжилтийг явуулах, унаган зүйл ургамлыг сэргээх, хөрсний элэгдлийг багасгах зэргээр бэлчээрийн эко системийн тэнцвэрийг хангах шаардлагатай болсныг харуулж байна.

Халдварт өвчний байдал

Төв аймгийн Баяндэлгэр сумын малчин өрх Багануураас Хэрлэнбаян-Улаан руу дураараа нүүж, тэнд байсан нутгийн малчны хотонд буусан, бэлчээр усаар нэгдсэн 14 өрхийн 488 мал өвчилж, 287 толгой мал хоргодож, 201 толгой малыг зориудаар устгасан байна. Зөвхөн Хэрлэнбаян-Улаанд 2022 оны 12 сарын 30-наас 2023 оны 03 сарын 02-ны хооронд хорио цээр халдваргүйтгэлийн арга хэмжээг иж бүрэн хэрэгжүүлсний үр

дунд дэглэмийг 03 сарын 15-нд цуцалсан. Түүнээс хойш шинж тэмдэг илрээгүй. Одоогоор тайван байгаа.

Дээрх өрхүүдийн 12 нь Төв аймаг, 1 нь Цэнхэр мандал, 1 нь Багануур дүүргийнх байсан байна. Гэхдээ отрын бүс нутагт малын халдварт өвчин гарсны ар дээр эдгээр айл өрхүүдэд ямар нэгэн хариуцлага тооцсон арга хэмжээ огт авагдаагүй байгаа юм

Сэг зэм устгал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А82 тоот тушаалын дагуу Мал эмнэлгийн ерөнхий газар болон Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа хооронд улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт мал, амьтны сэг, зэмийг устгах, цуглуулах, хашаа хороо, өтөг бууц, бэлчээр унд, усны эх булаг, худаг ус цэгийн орчны цэвэрлэгээ халдваргүйжүүлэх ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны 24 тоот гэрээ байгуулж, гэрээний дагуу 9 отрын бүс нутагт уг ажлыг зохион байгуулсан.

Орон нутагт ажилласан талаар

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг Хэрлэнбаян-Улаан, Малх, Чилэн, Хөх дэлийн бүс нутгуудад газар дээр нь, бусад 5 бүсийг онлайнаар хуралдаж МАА малчдын талаар Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл өгч, отрын бүс нутгийн нөхцөл байдлыг сонсон санал хүсэлтүүдийг нь авсан.

Уулзалтад Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын хэсгийн гишүүд, Хүнс, хөдөө аж ахуй,

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Аймаг дундын отрын бүс нутгийн захиргаа тухайн бүсийн аймгуудын Хунс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын ЗДТГ, Хөдөө аж ахуйн тасгийн төлөөлөл отрын бүс хариуцсан мэргэжилтнүүд тухайн бүс нутгийн малчид оролцсон.

Иргэд малчдаас гарсан санал.

1. Бэлчээрийн даац жил бүр 2-3 дахин хэтэрч орж байгаагаас бэлчээрийн ургамлын ургалт нөхөн сэргээхгүй байна. Хүнд хэцүү цагт отор ордог биш нутгийн уугуул иргэд байнга ордог. Гаднын оторчид хэт олон тооны малтай иргэдээс бэлчээр талхлагдаж, газрын гарцгүй болсон.

2-т, нутгийн уугуул иргэд, малчид нутгаа хамгаалан хайрлаад цаг хугацаандаа отрын бүс нутгаас гардаг бол гаднаас ирсэн малчид дураараа хоноцын сэтгэлээр ханддаг. Өвөлжөө, хаваржаа эвдэж, сүйтгэдэг олон бэрхиээлүүд байна.

3-т, отрын бүс нутгуудад байгаа түүхийн дурсгалт газруудыг хамгаалалтад авах зайлиггүй шаардлага бас байна.

4. Ан амьтан, бэлчээрээр бэлчдэг тарвага зурам элбэг байсан. Одоо нэн ховордсон, байгалийн бүтэц, амьтдын амьдрах нөхцөл алдагдаад байна.

5. Гаднын аймгаас ирж байгаа өрхүүд ихэнх нь цаг хугацаандаа гардаггүй. Одоо ч тийм дутагдлууд 07 сарын 01-ний өдрүүдэд ч бас байсаар байгаа юм. Чөлөөлсөн өрхүүдийн өвөлжөө хаваржааны бэлчээрийг зунд нь идүүлдэг сэг, зэмээ устгадаггүй зэрэг олон дутагдлууд байна.

7. оторчдыг илгээж байгаа аймгууд квотоос хэтэрсэн мал явуулах, мал эмнэлгийн гэрчилгээгүй, гарал үүслийн бичиггүй ирэх, өрхийн эрүүл

мэндийн дэвтэргүй байх, вакцин, тарилгадаа хамрагдаагүй ирэх, отрын бүсээ чөлөөлдөггүй зэрэг нийтлэг зөрчил тасралтгүй гарсаар байгаа юм.

Нутгийн иргэд өвөлжөө, хаваржаагаа тохижуулах өвөлжөөндөө орон сууц барих амьдрах бололцоогүй байна.

7. малын гоц салбарт өвчин гаднын аймгаас ирж байгаа малын хөлөөр гарсан нь батлагдаж байгаа юм.

Эдгээр цахим хуралд 5 бүсээс 28 хүн, Хөх дэл, Чилэнгийн ажлын хэсэгт 12 хүн, Хэрлэнбаян, Малхын ажлын хэсэгт 16 хүн, 200-аад малчид оролцож, санал бодлоо хэлцгээсэн.

Эдгээр гарсан саналыг нэгтгэхэд Хөх дэл, Чилэн, Хэрлэнбаян-Улаан, Малхын талын отрын бүсийг чөлөөлүүлэх хүсэлтийг тухайн нутгийн иргэд бас тавьсан юм. Бусад бүс өргөтгөх тохижуулах хүсэлт тавьсан талаар танилцуулбал Отрын талыг чөлөөлөх, Бага хайрхныг өргөтгөн тохижуулах, Хөх дэлийг чөлөөлөх, Чойбалсанг тохижуулах, Ачит нуурыг тохижуулах, Баяннурууг тохижуулах, Аргалантыг тохижуулах, Хэрлэнбаян-Улааныг чөлөөлөх, Чилэнг чөлөөлөх. Ийм хүсэлтүүдийг тухайн цахим болон ажлын хэсгийн биечилсэн уулзалтуудад илэрхийлсэн болно.

Дүгнэлт

Ажлын хэсэг аймаг дундын отрын бүс нутгуудад ажиллан дараах дүгнэлтийг гаргаж байна.

Отрын 9 бүсийн бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнээс харахад Аргалант Чилэн, Малх, Хөх дэл нутгууд цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй Хэрлэнбаян-Улаан дунд, Чойбалсан, Бага хайрхан, Баян нурууны отрын бүс нутгийн цөлжилтийн зэрэглэл сул зэрэглэлд байна. Аймаг дундын отрын бүс нутгийн ашиглалтын захиргаа,

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

удирдлага, хүний нөөц, мэргэжлийн боловсон хүчин, санхүүжилт, ажлын нөхцөл хангамж нь үйл ажиллагаагаа бүрэн хэмжээнд явуулах чадамжгүй болсон байна.

Отроор ирэгсэд нь мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдаагүй, эрүүл мэндийн гэрчилгээгүй, гарал үүслийн бичиггүй, тогтоосон маршрутаар нүүдэллэдэггүй, хугацаандаа гардаггүй, сэг зэмээ устгадаггүй зэргээс малын гоц халдварт өвчин дамжих бусад малчдыг эдийн засгийн хохиролд оруулах явдал байсаар байгаа юм байна.

Отрын бүс нутаг дахь түүхийн дурсгалт газар, соёлын өвийг сүйтгэх, нэн ховордсон ан амьтдыг устгах, зүй бусаар ашиглах явдал ч газар авсан байна. Отроор ирэх өрхийн нэрс ил тод бус, орон тооны бус зөвлөлийн шийдвэрээс илүү тоогоор ордог, хэн давуу эрх эдэлж байгаа нь тодорхой бус, хариуцлага хүлээдэггүй, татвар хураамж төлдөггүй зэрэг эмх замбараагүй байдал бий болсон байна.

Орон нутаг, отрын нүүдлийн талаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх, холбогдох дүрэм журмаа батлах, отрын бүсийн хилийн заагийг тодорхой болгох, ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газруудын талбайг бас нэмэгдүүлэх шаардлагатай байгаа гэж ингэж үзэж байна.

Санал

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд холбогдох эрх бүхий байгууллагуудын мэдээлэл танилцуулга болон отрын бүсийн аймаг, орон нутгийн иргэд, малчдын санал, хүсэлтийг сонсож нөхцөл байдалтай танилцаад дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Малх, Чилэн, Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутгийг улсын тусгай хэрэгцээний газраас бүрэн гаргах.

Аймаг дундын отрын бүс нутагт хамаарах соёлын өв, түүх дурсгалт газрыг тусгай хэрэгцээнээс гаргаж улсын тусгай хамгаалалтад авах.

Аймаг дундын отрын бүсийн ажиллах дүрэм, журмыг шинэчлэх. Бүс дамнахгүй босоо чиглэл дотор нүүдэл хийх, татвар хураамж бий болгох, хугацаандаа гараагүй малчдад хариуцлага тооцох түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Аймаг дундын отрын бүсийн захиргааг Улаанбаатарт байршуулах, бүсүүдэд ажиллах мэргэжилтнүүдийг автомашин, бензин шатахуунаар хангах, улсын байцаагчийн эрх олгох, цалингийн нэмэгдэл олгох зэргийг ажлыг зохион байгуулах.

Цаг хүндэрсэн үед ашиглах орон нутгийн тусгай хэрэгцээний газрын отрын бүс нутгийн бэлчээрийн хэмжээг нэмэгдүүлж, зүй зохистой ашиглах, тохижилт үйлчилгээ үзүүлэх дэмжлэг үзүүлэх

Монгол улсын нутаг дэвсгэрийн босоо чиглэлд отор нүүдэл зохион байгуулах, мал эмнэлгийн хяналтын явуулын постыг отрын малын далжин өнгөрөөх бэлчээрт байгуулах

Аймаг дундын отрын бэлчээрээр ашиглалтын бүртгэл хяналтын нэгдсэн систем нэвтрүүлэх, цахимжуулах зэрэг олон ажлуудыг хийх зайлиггүй шаардлага байна гэж үзэж байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат гишүүнд баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асуух асуулт гишүүд байна уу? Бейсен гишүүн. Бейсен гишүүнээр тасалъя. Бейсен гишүүний микрофоныг нээе.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: Аймаг дундын отрын бүс бэлчээр ашиглалтын талаар хэдэн асуулт асууж, бас саналаа хэлье гэж бодож байна. Манай аймаг бол ер нь отрын бүс тун багатай, бэлчээрийн талбай ч багатай тийм нутаг л даа. Ачит нуурын сав газрын 60 хувь нь Баян-Өлгий аймгийнх. Гэтэл захиргаа нь Увс дээр. Одоо хадланг ихэнх нь тэндээ хаддаг, тэгсэн мөртөө татвар төлөөд хадаж байгаа. Ногоон нуурын малчид, хадланчид.

Баяннуурын тэр УЦС баригдсанаар бараг 300-аад айлын хадланг тэгээд ирэх жилээс байхгүй болно. Тэгэхээр чинь энэ жил жишээлбэл пресс өвс чинь манайд 45 мянга, 50 мянга хүрсэн шүү дээ. Байдал улам хүндрэх юутай. Ихэнх газар нутаг нь тусгай хамгаалалттай юунаасаа хилийн дагуу бас зундаа заримдаа малаа оторлоод хил дагуу зусаад, мал тарга хөшөө авхуулах гээд байдаг. Энэ асуудал бас хүнд. Ялангуяа Ногоон нуур, Улаанхус, Цэнгэл, Сагсай, Алтай, Булган сумд. Энд нэлээн анхаарал хандуулахгүй бол тусгай хамгаалалттай газар ихэнх нь жишээлбэл Мөнххайрхан уулын хагас нь Хөх Сэрхийн нуруу, Хөх Сэрхийн нуруу, тэгээд Мөнххайрханы тийшээ Булган сумынхан оторлодог байсан. Зөвшөөрөл өгдөггүй, цас орохоор.

Бас Ховд аймгийн юутай, одоо бүр сүүлдээ Сэлхэн рүүгээ Увсын харьяа болгосон тусгай хамгаалалтын захиргааг нь. Дээлийн арал мөн адилхан Увсынх болгосон. Энэ дээр нэлээн анхаарал хандуулахгүй бол бас би газрын зураг, кадастрын зураг одоогийн энэ байгаль орчноос гаргаж байгаа кадастртай харьцуулж үзэхэд зөрөөтэй байна, ерөөсөө энэ. Зөрөөтэй гаргаж ирээд батлуулдаг, зөндөө л ярьж байна. Энэ тал дээр бас анхаарлаа хандуулах шаардлагатай байгаа юм.

хадлангийн асуудал дээр бүр болохгүй бол Сэлэнгэ ч юм уу бусад газраас хадлан хадуулах тал дээр Баян-

Өлгийд анхаарлаа хандуулахгүй бол болохгүй байна.

Малын тэжээл буюу тариалах юун дээр чинь Сагсай сум мөн Ногоон нуурын Ачит нуурын сав газраар ингээд тариалах боломжтой. Энэ дээр нэлээн анхаарал хандуулахгүй бол болохгүй байна. Энэ дээр бас анхаарч, шийдэж өгөх талаар ямар бодлого байгаа бол ер нь.

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат гишүүн хариулъя.

Ц.Идэрбат: Ер нь саяын ажлын хэсгийн дүгнэлт дээр бас та бүхэн сонссон байх. Ер нь манай Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 9 отрын бүс нутгийн захиргаа нэг 800 уугаад мянган га талбайд үндсэндээ 11 хүн л хяналт тавьж байгаа. Тэд нар нь унаа машин байхгүй, бензин тос байхгүй, томилолтын зардал байхгүй нэг иймэрхүү нөхцөл байдалтай байгаа. Тэгээд аймаг дундын отрын бүс нутаг учраас энэ отрын бүс нутгийн байрлал нь өөрөө 2-3 аймаг дамнасан байдаг. Тэгээд энэ 3 аймгийн хоорондох уялдаа холбоог тэнд байгаа хүн эсвэл энд байгаа тэр отрын бүс нутгийн захиргаа бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна гэдэг нь тодорхой байгаад байгаа юм. Тэгэхээр орон нутгуудад яг энэ ийм мэтчилний олон хүндрэлүүд үүсэж байгаа юм.

Бидний ажлын хэсгийнхэн цахим хурлыг хийхэд Ачит нуурын отрын бүс нутгийн ажилтан орсон тухайн үед. Энэ хүний хувьд бол бас бид ямар нэгэн байдлаар маргаан мэтгэлцээн байхгүй болдог гэсэн ийм зүйлийг танилцуулж байна лээ. Ер нь ингээд зүгээр амьдрал дээрээс ингээд хараад байхад энэ ажлын хэсгийн ингээд ажлыг ахалж ажилласан хүний хувьд хэлэхэд ялангуяа алслагдсан аймгуудад байгаа тэр отрын бүс нутаг бол тухайн нутгийнхаа л хүмүүст бас үйлчилдэг учраас. Тэгээд аймаг дундын маргаан мэтгэлцээн бас 1 дүгээрт бага юм байна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Яг таны асуусан Ачит нуурын хувьд энэ 9 отрын бүс нутгаас хамгийн бага нь буюу 28,9 мянган га нутгийг хамардаг юм байна лээ. Тэгээд бас зарим дээр нь ингээд аваад үзэхээр ер нь нэг 20-30 мянга, 40 мянган га газартай газруудад үндсэндээ аймаг дундын отрын бүс нутаг гэж хэлж байгаа болов чиг нэг өвөлдөө 20, 30 өрх л орж өвөлждөг. Тэр 20, 30 өрх нь яаж, хэний зөвшөөрлөөр, яаж ороод байгаа нь мэдэгддэггүй гээд энэ аймаг дундын отрын бүс нутаг дээр ер нь нэлээн хүндрэлтэй зүйлүүд байдаг юм байна. Тэгэхдээ би үүнийг зөвхөн отрын бүс нутгийн захиргааны үйл ажиллагаа буруу явж байна гэхээсээ илүүтэйгээр тэнд байгаа хүмүүсийн ажиллах нөхцөл бололцоо ч ер нь маш хүнд юм билээ. Маш хүнд юм байна. Тэгэхээр энэ аймаг дундын отрын бүс нутгийн захиргааны энэ баримталж ажиллах журам, тэр хариуцлагын тогтолцоо. Тийшээ хэн орж өвөлжих вэ? Эд нар гэдэг энэ зүйлийг бас Засгийн газар дээрээ нэлээн сайн эргэж харж шийдвэрлэвэл хэрвээ аймаг дундын отрын бүс нутаг гэж байх ёстой юм бол тэрийг удирдах ийм нэгж ажиллах ёстой юм бол энэ нэгж байсан шиг байж ажиллах бүхий л бололцоогоор нь хангах нь зүйтэй л гэсэн. Ийм л чигтэй байгаа юм.

Тэгээд энэ чинь аймгийн та хэлж байна. Баян-Өлгийн газар нутгийн 60 хувь гэж байна. Гэхдээ Увсад харьяалагдаад байна гэж байна. Тэгээд энэ болгоныг яг тухайн отрын бүс нутгийн захиргаа хаанаа байх вэ гэдгийг ч хүртэл энэ отрын бүс нутгийн захиргаа шийдвэрлээд ингээд явах нь зүйтэй л гэж ингэж л би хэлэх гэж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Бейсен гишүүн дахин тодруулъя.

Б.Бейсен: Идэрбат гишүүн бас буруу ойлгочих шиг боллоо. Баян-Өлгий аймгийн газар нутгийн 60 хувь нь Увсад гээд. Ачит нуурын сав газрын гэж ярьж байгаа байхгүй юу. Одоо энэ байгаль орчноос гаргаж байгаа кадастрын

зургийг жинхэнэ газрын зураг бий шүү дээ. Тэрэнтэй харьцуулж үзэхэд зөрөөтэй байгаа байхгүй юу. Би харьцуулж үзсэн. Энэ асуудал чинь тэнд өвөлжиж байгаа жишээлбэл Ховд голын сав газарт чинь 9 сард ороод 6 сарын 15-ыг хүртэл бараг 10 сар тэнд намаржаа, өвөлжөө, хаваржаа нь тэнд байдаг байхгүй юу. Уулархаг нутгаар ер нь зусах ямар ч боломжгүй цас орчихдог, хүйтэн, тачирхан өвстэй. Энэ дээр нэлээн анхаарал хандуулаад энэ газар дээр нь очоод шалгаад үзээрэй. Түүрүн бас ажлын хэсэг гарсан. Бид нар Батжаргал гишүүн бас ажил гараад очиж амжаагүй. Нэлээн маргаантай асуудал байгаа шүү. Тэр сүүлдээ татвар оногдуулах энэ тусгай хамгаалалттай газрын хууль гэдгээрээ. Ийм маргаантай асуудлууд байж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хэлэх гишүүд байна уу, саналаа өгнө үү. Ганибал гишүүн, Батжаргал гишүүнээр тасаллаа. Ганибал гишүүн.

Н.Ганибал: Отрын бүс нутгийн асуудал маш чухал болсон. Өнөөдрийн явж байгаа байдлууд бол угаасаа бүтэхгүй л дээ. Ямар ч явцгүй болсон. Яах вэ, сайжруулалтын талаар хэдүүлээ ингээд төслөө дэмжээд оруулчихна. Засгийн газар энэ дээр арга хэмжээ авах ёстой л доо. Тэгээд төсөв батлах үед отрын бүс нутгийн захиргааны зардал гэдэг ойлголт ер нь бараг ингээд л жилээс жилд багасаад, ингээд л яваад байгаа юм. Яг ингээд бодит нөхцөл байдлуудыг маш сайн ойлгоод байна л даа хэдүүлээ. Яг Идэрбат гишүүний хэлээд байгаа бүх юм бодит үнэн.

Ер нь бид нар тэр отрын бүс нутгийг хамгаалах тухай ойлголт гараад ирэхээр ер нь одоогийн байдлаар ер нь зүгээр хамгаалалт гэдэг ер нь юу юм бэ гэдэг ойлголт хэдүүлээ ярих ёстой юм байна лээ. Хамгаалах, яаж хамгаалах юм

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бэ гээд. Тэрийг хашиж хамгаалах юм уу бэлчээрийг хашиж л хамгаална, бэлчээрийг манаж хамгаална гэж байхгүй. Тэр бэлчээр дээр ямар нэгэн алдуул малууд яваад ороход тэрийг бид нар хамгаалах, хөөж туух гэдэг ойлголт байх юм уу, нэг эсвэл энэ асуудлаа хэдүүлээ эхлээд тодорхой болгомоор юм байна лээ. Түүнээс отрын бүс нутаг гээд тодорхой заагтай ингээд хязгаарыг заагаад өгдөг. Дунд нь хэдэн худаг ухчихсан байгаа. Хэдэн өвсний тэжээлийн фондууд хийчихсэн байгаа. Тэгээд тэндээсээ дотроос нь өөрсдөө хадлан хадаад өнөөдөр өвсөө бэлдэж байгаа.

Цаашилаад түрүүний Бейсен гишүүний хэлээд байгаа яг үнэн байхгүй юу. Отрын бүс нутгийн эзэн нь тухайн бүс нутгийг хариуцаж байгаа тэр дарга захиргааныхан болчихоод байгаа байхгүй юу. Тэд л ямар хүмүүстэй гэрээ хийх вэ. Хэнийг оруулах вэ.

Одоо Дорнодын Чойбалсангийн бүс нутаг бол тэр чигээрээ мянгаас дээш адуутай хүмүүсийн л нутаг болчихсон шүү дээ. Тэнд ямар нэгэн нуугаад байх юм байхгүй. Хамгийн сүүлчийн цэг, хил тулгаад очсон, тэнд хамгийн олон адуутай хүмүүс тэнд өнөөдөр амьдарч байгаа. Тэр хүмүүсийг хэн хамгаалдаг вэ гэхээрээ тухайн бүс нутгийг хариуцсан дарга хамгаалдаг. Энэ өнөөдөр бид нарын хүлээгээд, хүсээд байгаа отрын бүс нутаг биш болчихсон байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ дээр хамгаална гэдэг ойлголтоо маш зөв болгох ёстой, тэр айл гаргана, гаргахгүй нөгөө малчдын ухамсрын асуудлыг бас давхар ярьж байна шүү дээ тийм үү. Очоод бүс нутагт орчихоод нэг жил болно нэг өвөлжинө өө л гэхээд. Тэгээд бүтэн 4, 5 жил болж байгаа айлууд хүртэл байж л байгаа. Зүгээр адуугаа тууж очоод, тэнд худаг ухаад амьдарч байгаа хүмүүс ч бас байгаа. Тэгэхээр энэ болгон дээр бодит үйл ажиллагаа дээр маш сайн тодорхой болгоод, хамгаална гэдэг нь үүнийг хэлж байгаа юм. Гарна гэдэг нь үүнийг хэлж байгаа юм, буцаад ашиглана гэдэг нь үүнийг хэлж байгаа юм

гэдэг тэр тодорхой асуудлуудыг нь хийж өгөөд, дээрээс нь санхүүгийн хувьд сайн дэмжиж өгөхгүй бол энэ угаасаа боломжгүй болчихоод л байгаа асуудал байхгүй юу. Тийм ээ.

Тэгэхээр хэдүүлээ энэ дээр Засгийн газрыг маш сайн шахаж ажиллуулахгүй бол орхигдсон нэг тийм байгууллага бий болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийгээ эргээд хяналтаа эргээд хэдүүлээ бас тавих тал дээрээ эргэж юу гэдэг юм, Засгийн газар төдий хэмжээний хугацаанд энэ нь тайлангаа тавиад, энэ жилийн төсөв дээр төдий хэмжээгээр орлогоо нэмэгдүүлсэн биш ээ, төсвөө нэмэгдүүлээд тэнд төсөв мөнгө тавьж өгсөн талаарх мэдээллийг нь маш сайн шахаж ажиллуулахгүй бол эргээд л нөгөө нэг давтагдсан ийм цаг хугацаа эргээд бий болчих байх гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүн саналаа хэлье.

Ж.Батжаргал: Отрын нөөц нутгуудын байдал амаргүй байгаа. Энэ яах аргагүй ашиглалттай холбоотой энэ ашиглалтын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа захиргаатай холбоотой юм. Тийм учраас үүнийг бид нэлээн өөр өнцгөөс харах ёстой юм байна лээ. Тийм учраас энэ отрын бүс нутгийн харилцааны асуудлыг Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тэр бэлчээрийн газрын харилцаа зохицуулж байгаа одоо энэ өргөн баригдаад явж байгаа хууль дотор бид нар нэлээн оруулсан. Гэхдээ сая яваад үзэхээр үүн дээр суурь заалтуудыг нь илүүтэй дахиж татаж авах ёстой юм байна гэдэг ийм ойлголт их тодорхой болсон. Тийм учраас би эрх зүйн үндсэн зохицуулалт юмнууд нь үүгээр нэг жосохон тодорхой болж гарч ирэх болов уу гэсэн нэг ийм бодол байна гэж.

Одоо гарах гэж байгаа яг тогтоолтой холбогдуулаад хэлэхээр зэрэг аймаг дундын, сум дундын, сумын энэ

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

отрын нөөц нутгуудын зохистой ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын энэ харилцааг зохицуулсан журмыг шинэчилж гаргаж, нэлээн сайн мөрдөх тухай асуудал нэг байгаад байна.

2 дугаарт, ерөөсөө туурга тусдаа бол тусын дайсан гэдэг шиг энэ сум, орон нутгууд байгаль цаг уурын хүнд нөхцөлд мал сүргээ давын өмнө өөрсдөө аваад гарах бололцоо боломжоо бүрдүүлсэн сумын өөрийн отрын нөөц нутаг, аймгийн өөрийн отрын нөөц нутгуудынхаа хэмжээг нэмэгдүүлэх талын бодлого барьж ажиллах зайлшгүй шаардлага байгаа. Гэхдээ байгалийн хараат аж ахуй учраас байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас зайлшгүй нүүдэл суудлын асуудал байгаа. Үүнийг нь аймаг дундын отрын нөөц нутгаар зөв зохицуулах зайлшгүй шаардлага байгаа. Тийм учраас эдгээр нутгуудын талбайн хэмжээг нэмэгдүүлэх талын асуудлыг л бид ер нь ярихгүй бол боломгүй болчхоод байгаа. Одоо байгаа 9 газар дээр дээрээ ажлын хэсэг ажиллаад, үүнийг чөлөөлөх, үүнийг чөлөөлөх гэж хэдүүлээ дуугарамгүй байна. Ерөөсөө үүн дээрээ тэр мэргэжлийн байгууллагуудаараа бодитой дүн шинжилгээ хийлгээд, тэгээд хариугүй бага талбайгаар авагдчихсан энэ отрын нөөц нутгууд чинь үндсэндээ үүргээ гүйцэтгэж чадахгүй байна шүү. Тэгээд энэ бүх юмнуудаа тал бүрээс нь судалж үзээд санал, дүгнэлтээ оруулж ирээч ээ гэдэг санааг л бид Засгийн газарт өгөх ёстой гэж би энэ талаас нь харж бодоод байна.

3 дахь зүйл, отрын энэ захиргааны орон тоо, ажиллах боломж, унаа унаш, тэгээд тэр тодорхой байцаагчийн эрх, тэр холбогдох хүмүүст арга хэмжээ барьдаг, авдаг, барьдаг энэ эрх мэдэл бүх юмыг нь цогцоор нь өгөх ёстой юм байна лээ. Тэгэхгүйгээр бид энд ямарваа нэгэн ажил юмнууд явахад үнэхээрийн хүндрэлтэй байгаа. Болохгүй байна лээ.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл. Бүх зүйлийг отрын бүс нутаг руу авамгүй

байгаа юм. Би тэгж л бодоод байгаа юм. Отрын бүс нутгийг өөр дээрээ агуулж байгаа сум, аймаг 2 мал эмнэлгийнх нь ч асуудлыг, хүн эмнэлгийнх нь ч асуудлыг, сургууль боловсролынх нь ч асуудлыг, тэр худалдаа үйлчилгээнийх нь ч асуудлыг хариуцмаар байгаа юм. Харин зардал талд нь нэмэлт зардлыг нь тусгаж өгмөөр байгаа байхгүй юу. Тэр отрын нөөц нутагтай холбоотой гарч байгаа мал эмнэлгийн нэмэлт зардлын асуудлыг, хүн эмнэлгийн нэмэлт зардлын асуудлыг, сургууль цэцэрлэгтэй холбоотой нэмэлт гарч байгаа зардлуудыг тэр сум орон нутгийнх нь төсөв дотор хийж өгмөөр байгаа юм. Тэгж байж энэ ерөөсөө зөв болох ёстой. Тэгэхгүй бол үүнийг дагаад нэг баахан хяналтын пост нэртэй худлаа үнэн орон тоо нэмсэн нэг ийм юм болж хувирчих гээд болж өгөхгүй байгаа юм. Үүнийг нэг зөв бодмоор байна.

Тэгээд энэ чинь 800-аад мянга байна уу. Энэ отрын яг улсын аймаг дундын нөөц нь. Тэрний бараг 200 хэдэн мянга нь Хэрлэнбаян-Улаан байгаад байгаа биз дээ. Үгүй ээ тэгээд үнэхээр л энэ отрын нөөц нутгийн захиргаа нь хөдөө гардаг юм бол тэр нийт нутаг дэвсгэрийнхээ бараг 30-аад хувь гаруй хувийг эзэлж байгаа Хэрлэнбаян-Улаан руугаа л гарна биз дээ. 30 хэдхэн мянган га-тай Чилэн рүү гарч явахын хооронд энэ чинь, дэндүү дамтуурч байгаагийн илэрхийлэл байхгүй юу энэ бол.

Тийм учраас энэ отрын нөөц нутгийн улсын хэмжээний тэр захиргаа нь оновчтой газраа байршаад, үйл ажиллагаагаа явуулах тухай, тэр 9 отрын нөөц нутаг дээрээ ажиллаж байгаа улсууд нь ... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүнд 1 минут нэмье.

Ж.Батжаргал: Юм үлдэхгүй л юм шиг болох гээд байна л даа. Тэгээд ингэж ажилламаар байна. Нээрээ, тоглоом байхгүй. Тийм учраас бид нарын гарах

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тогтоол ер нь ийм агууламжтай гарах нь зөв өө.

Дээр нь тэр мэдээж цаг байдал хүндрэхээр зэрэг малыг онд мэнд оруулахын тулд нэмэлт тэжээлийн тухай асуудал яриад нэг жоохон ногоон тэжээл тарих тухай юм яриад байгаа юм. Өнчин ганц трактортой, бараг үр байхгүй, талбайн боловсруулалт байхгүй, тэгээд ер нь яаж юм тарьж юм хураана. Тэр чаддаг технологитой, техниктэй тэр аж ахуйн байгууллага энэ тэртэй нь талбайгаа гэрээлэх хэлбэрээр юмаа тариулаад авч чаддаг, найдвартай ургацаа авч чаддаг энэ зөв хэлбэр лүүгээ явахгүй бол явахгүй ээ, энэ боломгүй юм байна лээ. Яг үнэндээ. Сая бид нар Чилэнг очоод үзээ биз дээ. 200 га-д тарина гээд газрын боловсруулалт хийсэн юм байхгүй, үр ч байхгүй, нэг ийм л юм байж байгаа байхгүй юу. Тэгээд тэнд ажиллах хүн нь ... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат гишүүний, өөрөөр хэлбэл ажлын хэсгээс гарсан санал дээр бас нэг цөөхөн хэдэн зүйл хэлчихмээр байна. Бидний аймаг дундын отрын бүс нутаг гэдэг маань цаг хугацааны хувьд ер нь байгаль дэлхий маань бас гандаж байгаатай уялдаатайгаар үүрэг роль гүйцэтгэхээсээ өнгөрчхөөд байна гэж бид ажлын хэсэг гарч явсан, үзсэн. Тэгээд урьд өмнө, бас сайхан аятайхан бүс нутгаа бид нар мэдээж отрын бүс нутаг гээд тодорхойлсон байж таараа. Тэгээд ингээд эргээд харахад сая тэр ярьсан шүү дээ. Байгаль юуны ус цаг уур орчны мэдээллийн юу билээ? Орчны мэдээлэл судалгааны хүрээлэнгээс гаргасан дүгнэлтээс харахад одоо энэ аймаг дундын отрын бүс нутаг чинь нутаг маань өөрөө малынхаа даацыг хангахаа больсон, чанаргүй болсон, ургамлын төрөл зүйл нь алга болсон, ер нь цөлжих тал руугаа орсон ийм бүс байгаад байна шүү дээ. Тэгээд энэ бүсийгээ бид нар болохоор хувааж идчих гээд л хэдэн талаас нь зулгаагаад тэрийгээ гайхалтай бүс юм шиг ингээд байдалтай хэдэн

талаас нь хараад байдаг. Өчнөөн олон хүмүүс энэ дээр нь ажиллаад байдаг, тэгээд орж байгаа, отрынх нь малчид нь гээд тэгэхээр жишээ нь Булган дээр нэг 20 хэдэн өрх тэнд өвөлждөг. Тэгээд тэндээс 10 хэд нь тал нь тэндээ бүр байнгын гардаг ч үгүй. Тэгээд цаана нь 5, 6 сумаас нэг 2, 3, 2, 3 айл өрх гээд ингээд 1 ерөөсөө л 10 хэдхэн айлын өрхийн л асуудлыг ярьж байдаг. Тэгээд түрүүн бас танилцуулга дотор орлоо шүү дээ. Ерөөсөө үүнийг өмчилж мэдэж байгаа нь ерөөсөө тэр нэг отрын бүсийн нэг хэдэн хүмүүсийн мэдэлд л байж байдаг. Хаа байсан тэр Завханаас нүүж хурч ирээд л Монгол Улсыг хөндлөн гулд нүүж хурч ирж байгаад л тэгээд л Хэнтийд очоод өвөлжиж, хаваржаад, зусаад явж байдаг ч гэх жишээтэй.

Нөгөө талаар энэ отрын бүсэд гарч байгаа малын өвчинтэй асуудлууд нэлээн өндөр хэмжээнд яригдахаар хэмжээнд оччихсон байна. Ер нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульдаа бид нар заасан шүү дээ. Энэ шилжилт хөдөлгөөнийг ер нь хорьж байж бид нар энэ малын өвчнөө барина. Гэтэл энд дандаа хаа хамаагүй эсрэгээр отрын бүс рүү очлоо гээд л ингээд л нүүдэл суудалтай явж байдаг. Хаанаас ирж байгаа, ямар хэмжээнд малаа эрүүлжүүлсэн, мал эмнэлгийн бичиг байхгүй, тэгээд тэрийгээ араасаа өгнө энээ тэрээ гэсэн хэл үгтэйгээр тэгээд л ерөөсөө нүүгээд л ингээд л явж байдаг. Зарим газар отрын бүс нь яг хаанаа байгаа нь мэдэгдэхгүй отрын бүс гэдгээр шууд нүүгээд нүүгээд ямар нэгэн зөвшөөрөлгүй нүүлт нүүдэл суудлууд ингээд яваад байгаа шүү дээ. Тэгээд энэ мэтчилэн олон асуудлууд байгаад байна.

Тийм болохоор өнөөдрийн энэ бас ажлын хэсгээс гарч байгаа тогтоолын төслийг дэмжиж байгаа юм. Тэгээд ер нь зүгээр чанарыг сайжруулъя. Дотор зохион байгуулалтыг сайжруулъя. Тэр тусмаа энэ унаа унашаар болон мэргэжлийн байгууллагын хэмжээнд авч ажиллуулдаг. Тэгээд тодорхой хэмжээнд

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

отрын байгууллага нь отрын бүс нь хоорондоо хэлцлүүдээ хийж байдаг, аймаг дундын, сум дундын хооронд нь хэлцлүүдийг нь хийж байж зохион байгуулалт хийж байдаг, зохицуулалтыг нь хийж байдаг, нүүдэл суудлыг нь зохицуулж байдаг, малын өвчин халдварт өвчин болон бусад урьдчилан сэргийлэх ажлуудаа хийж байдаг гэх мэтчилэн засаж залруулах ажлууд маш их байна. Тийм болохоор энэ өнөөдрийн тогтоолд 7 зүйл, заалттай энд бүх зүйлүүд нь орсон байна л гэж үзээд байна гэж.

Ингээд гишүүд тогтоолын төсөлтэй холбоотой санал хэлж дууслаа.

Ингээд “Аймаг дундын отрын бүс нутаг, бэлчээр ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тодруулъя гэж байна уу?
Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Нэг ажлын хэсэг ажиллаад ийм хамаагүй үг хэллэгтэй тогтоол гаргаж болохгүй ээ. Эхний 2 заалт эд нарыг яг энэ агуулгаар нь гаргаж болохгүй. Отрын нөөц нутгууд энэ юунуудын юугаар ийм доройтолд орчихсон байна. Зарим нь бүр ингээд талбайн хэмжээнийхээ хувьд отрын нөөц нутгийн хэмжээнд хүрэхээргүй байна. Үнэхээрийн даац юмаа дийлэхгүй болчихсон юм байна. Тэгэхээр энэ бүх юман дээрээ мэргэжлийн байгууллагуудаараа судалгаа дүгнэлт хийлгээд хэрхэх эсэх саналаа оруулж ир гэдгийг л Засгийн газарт бид өгмөөр байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр би бол санал хураалтыг хүчингүй болгохгүй. Хэрвээ тогтоолоо агуулга дээр ийм өөрчлөлт хийхгүй ээ гэвэл санал өгөхгүй ээ. Энэ чинь Монгол түмний хэдэн 100 жил эрхэлж ирсэн нүүдлийн МАА-г нь ганц авч явж байгаа гэж бодоод социализмын үед 50 онд

эхлүүлчихсэн юмыг өнөөдөр гэв гэнэтхэн 4, 5 гишүүн хэдэн тийшээ гарч яваад ирээд устгачих бодлого барьж болохгүй байхгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат гишүүн тайлбар хийе.

Ц.Идэрбат: Энэ Байнгын хорооны тогтоол эцсийн шийдвэр биш ээ. Батжаргал гишүүний саяын хэлж байгаа, ярьж байгаа зүйлийг Засгийн газар дээрээ ярилцаад тэр мэргэжлийн байгууллагууд нь санал онолоо дүгнээд ингээд явах нь зүйтэй. Тэндээс эргээд Засгийн газраас Байнгын хороо руу санал орж ирэхгүй шүү дээ. Засгийн газар өөрөө тэндээс шийднэ, Засгийн газрын тогтоолоороо.

Манай ажлын хэсгийн хувьд бол бас тодорхой хэмжээнд энэ мэргэжлийн байгууллагуудынх нь санал, дүгнэлт бүх юмыг сонссон. Ер нь үндсэндээ нэг 3 үндсэн зүйл л байгаа юм. Ер нь Засгийн газар энэ отрын бүс нутгийнхаа асуудлыг бас нэг эргэж нэг хараач. Одоо энэ Чилэнгийн отрын бүс нутаг гэж яриад байгаа өргөөшөө 4 км, нарийндаа 2 км, уртаашаа 50 км гэж байгаа юм. Голд нь айл буучихад отрын бүс нутгаасаа гараад явчихдаг. Үгүй ээ, ийм отрын бүс. Малх дээр очоод ингээд уулзахаар 2007 онд гэсэн байх. Юуг нь ч мэдээгүй байтал гэнэт л отрын бүс нутаг гэж зарлаад л тэгээд л бид нарыг ийм хэцүү байдалд оруулчихсан гэх жишээтэй. Хэрлэнбаян-Улаан дээр яваад очиход 30 жил ярьж байна. 200 мянган га газрыг ингэж улсын тусгай хэрэгцээнд гэж ингэж авчхаад хоёрхон хүнд хариуцуулчихаад явган нүцгэн 2 хүнд хариуцуулчихаад ямар ч хяналт байхгүй. Өнөөдөр аймаг дундын отрын бүс нутаг Хэрлэнбаян-Улаан 27, найман халдварт өвчний голомттой болчихсон гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр ер нь үнэхээр Монгол Улсын Засгийн газраас энэ отрын бүс нутаг байх эсэхээ нэг эхлээд нэг ярьчих хэрэгтэй байх. Хэрвээ үнэхээр байх ёстой гэж үзэж байгаа бол байлгахын дайтай

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байлгаач ээ гэдэг ийм юм яригдаад байгаа юм. Тэгэхээр яах вэ, энэ Чилэн, Малх, Хэрлэнбаян-Улаанаас ард иргэдээс очоод уулзалт дээр манайхыг гаргаж өгөөч ээ гээд шулуухан хэлсэн учраас үүнийг нь оруулж байгаа юм. Түүнээс 9-үүлэнг нь байхгүй болгоно гэж огт хэлээгүй, огт хэлээгүй.

Тэгэхээр энэ бол Засгийн газрын бүрэн эрхийн асуудал. 1 дүгээрт, эргэж харах, 2 дугаарт, өнөөдөр энэ отрын бүс нутгийн үйл ажиллагаа ямар ч дүрэм журамгүй зэрлэг байдлаар явж байгаа шүү дээ. Үүнийг бүгд мэдэж байгаа. Отрын бүс нутгийн захиргаа нь арга хэмжээ авъя, бариад явчих журам байхгүй, дүрэм байхгүй. Нэг ингээд журмаа бариад явахаар өөрсдөө шүдгүй арслан шиг явган нүцгэн ийм хэдэн хүмүүс. Тэгэхээр бид нар энэ дүрэм, журам хамаг юм, хариуцлагынхаа тогтолцоог хүртэл бүр нэг тодорхой болгож өгмөөр байгаа юм.

3 дугаарт нь, юу гэхээр үнэхээр отрын бүс нутаг гэж байгаад энэ захиргаа байх юм бол хаана байрлахаасаа авхуулаад тэд нар ямар эрхтэй байх юм, хэзээ, хаана, яаж хяналтаа тавих юм, хөрөнгө мөнгө нь юу байх юм. Ийм байдалтай орохгүй бол нөгөө 430 хэдэн сая төгрөг тавьчаад нэг 20 хэдэн хүнийг цалинжуулаад, тэгээд ямар ч хяналтгүй явж байгаа юм. Үүний тод жишээ бол энэ би Хэрлэнбаян-Улаан дээр гараад байгаа 20 хэдэн малын өвчний голомтын асуудал байгаа байхгүй юу. Малхын тал дээр очиход ахмад малын эмч Ганбаатар гэсэн байх, хүн хэлж байна лээ шүү дээ. Энэ Монгол Улсад гараад байгаа малын өвчний гол шалтгаан ердөө л энэ замбараагүй явалт, нүүдэл суудлууд байгаа юм гээд.

Тэгэхээр ер нь энэ Засгийн газраас энэ отрын бүс нутгийнхаа асуудлыг эргэж нэг хараад, дүрэм журмыг нь сайжруулаад хэрвээ байх ёстой гэж байгаа бол байлгахын дайтай байлгаад хөрөнгө санхүүг нь тавиад ингээд явах нь

зүйтэй л гэж ингэж бодож байгаа юм. Ингэж бодож байгаа юм. Түүнээс бол бүх отрын нутгийг байхгүй болгоё ч гэдэг юм уу, тийм асуудал байхгүй. Тэр бол Засгийн газрын бүрэн эрхийн асуудал.

Манай Байнгын хорооноос гарсан ажлын хэсэг бол энэ газар дээр нь танилцаад саналаа явуулах л ийм л бүрэн эрхийн хүрээнд бидний үйл ажиллагаа явна. Тийм учраас бас нэгэнт бид нар ажиллаад ингээд явсан бол тодорхой бас саналуудыг нь гаргаад явах нь зүйтэй гэж ингэж л хэлэх гээд байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгээд яах вэ, Малх, Чилэн, Хэрлэнбаян-Улаан гэдэг чинь өөрсдөө малчдынх нь хүрээнд аймгийн хүрээнд бас нэлээд саналуудаа гаргачаад тэгээд саналынх нь саналыг үндэслэж л иймэрхүү санал тогтоолын төсөл орж ирсэн шүү дээ. Ингэж болох юм.

Малх, Чилэн, Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутгийг улсын хэрэгцээнээс гаргах талаарх орон нутгаас гаргасан саналыг мэргэжлийн байгууллагуудын хүрээнд судалж, дүгнэлт гаргах гэж. Дүгнэлт гаргах. Гаргах саналыг бүрэн, хэрэгцээнээс гаргах саналыг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт дээр үндэслэж гаргах саналыг мэргэжлийн байгууллагууд.

Ингэе, энэ нэрийг хасчихъя. Нэрийг хасъя. Тэгээд зарим отрын бүс нутгуудыг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэсэн.

Орчны отрын бүс нутгийн, улсын бүс нутгийн талаар мэргэжлийн байгууллага, Цаг уур, орчны мэдээлэл судалгааны хүрээлэнгийн гээд хаалтад хүрээлэнгийн дүгнэлтийг гаргаж танилцуулах гээд оруулъя. Бүр мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулъя.

Тэгвэл отрын бүс нутгийн талаар мэргэжлийн байгууллагын байгаль орчин биш ээ, тийм. Мэргэжлийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгууллагуудын дүгнэлтийг гаргаж, тодорхой арга хэмжээ авах. Отрын бүс нутгийн талаар мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг гаргаж, холбогдох арга хэмжээ авах гэдгээр явах уу. Тэгвэл 1 дүгээр заалтыг ийм байдлаар өөрчилье. Тэгээд 2 дахь заалт бусад заалтууд үлдэж байгаа шүү.

Ингээд санал хураалт. 2 дугаар заалт дээр найруулгыг үзье. Түүнээс биш энэ одоо соёлын өв, түүхийн дурсгалт газрыг тусгай хэрэгцээнээс гаргаж тусгай хэрэгцээнд гарч улсын тусгай хамгаалалтад авъя гэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас дүгнэлт гараад байгаа юм уу. Тийм, тийм тусгай хамгаалалтад тусгай хамгаалалтад аймаг дундын отрын бүс нутагт хамаарах соёлын өв, түүхийн дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалтад авах гэж томъёолъё.

Тэгээд та санал гаргая гэсэн. Саяын санал хураалтыг хүчингүй болгох гэсэн саналд чинь та микрофонд хэлнэ үү? Батжаргал гишүүний микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Тийм, шийдвэрийн төсөл боловсруулсан ажлын хэсэг Их Хурлын гишүүдтэй санал бодол хуваалцаад байр суурь өөрчлөгдөн нэгдэж байгаагаар холбогдуулаад өмнөх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт хийж өгөхийг хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүний гаргасан зарчмын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт. Санал хураалт.

54,5 хувиар санал хураалт хүчингүй боллоо.

Тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

54,5 хувиар санал, тогтоолын төсөл батлагдлаа.

Дараагийн асуудлыг хэлэлцье.

“Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийх санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхний гар дээр тараачихсан байгаа.

Санал хураалт.

54,5 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Ингээд өнөөдрийн хуралд идэвхтэй оролцсон гишүүддээ талархлаа.

Өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье.

16.27 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

16.26 цаг